




МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2017 • IX • № 11



Б.ЭРДЭНЭХУЯГ:
ХУУЛИЙН
ӨӨРЧЛӨЛТӨӨР
МОНГОЛБАНКНЫ БИЕ
ДААСАН, ХАРААТ
БУС БАЙДЛЫН
ҮЗҮҮЛЭЛТИЙН
ТҮВШИН 80 ХУВЬД
ХҮРНЭ

МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН
МЭДЭГДЭЛ
БОДЛОГЫН
ХҮҮГ ХЭВЭЭР
ХАДГАЛАХ
ТУХАЙ

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

"Монгол Улсын Эрдэнэсийн сан" номноос.



Mongolbank.mn



@mongolbank_mn



www.mongolbank.mn



Mongolbankmn



МОНГОЛБАНКНЫ ЗҮҮН БҮСИЙН УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨНИЙГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Монголбанкны Зүүн бүсийн удирдах ажилтнуудын зөвлөгөөнийг 2017 оны 09 дүгээр сарын 07-ноос 10-ны өдрүүдэд зохион байгууллаа. Зөвлөгөөнийг нээж Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх Д.Аюуш үг хэлж, Тамгын газар, Судалгаа статистикийн газар, Хяналт шалгалтын газар, Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын төлөөллүүд "Төв банкны тухай хууль", "Банкны тухай хууль", "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын нэмэлт өөрчлөлт, "Монгол алт" аяны явц зэрэг сэдвүүдээр лекц сургалт хийв. Түүнчлэн Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад "Төв банк юу хийдэг вэ?", "Санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх нь" сэдвээр сэтгүүлчдэд "Төв банкны олон нийттэй харилцах харилцаа" зэрэг сэдвүүдээр тус тус илтгэл тавьж, хэлэлцүүлэг хийлээ. Зөвлөгөөний нээлтэд Сүхбаатар аймгийн засаг дарга, засаг даргын орлогч, аймгийн төрийн сангийн дарга болон арилжааны

банкуудын захирлууд, ажилтнууд оролцлоо. Мөн Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймаг дахь Монголбанкны салбарын захирлууд салбарынхаа үйл ажиллагааны талаар танилцуулга хийн, тулгарч буй асуудлуудаа тодорхойлж, санал бодлоо илэрхийллээ.

Энэ үеэр Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх Д.Аюуш, ТГ-ын захирал А.Энхжин, ССГ-ын захирал Д.Ган-Очир нар аймгийн засаг дарга З.Энхтөртэй уулзалт хийж санал бодлоо солилцов.

Сүхбаатар аймаг дахь Хаан, Хас, Төрийн банкны салбар тооцооны төв, Төв аймгийн Баяндэлгэр суманд байрлах Хаан болон Төрийн банкны тооцооны төв, Хэнтий аймаг дахь Төрийн банкны үйл ажиллагаатай танилцаж, удирдлагуудтай нь уулзлаа.

Зөвлөгөөнд оролцогчид Зүүн бүсийн зөвлөгөөнийг амжилттай болсныг онцлоод, цаашид энэхүү үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах нь зүйтэй гэдэг дээр санал нэгдэв.

Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох мэдээ:

9-р сарын онцлох үйл явдлууд

ХУУДАС

4

Ярилцлага:

Б.Эрдэнэхуяг: Хуулийн өөрчлөлтөөр Монголбанкны бие даасан, хараат бус байдлын үзүүлэлтийн түвшин 80 хувьд хүрнэ

ХУУДАС

6

Асуулт, хариулт:

Монголбанкны Хэвлэлийн хурлаас ...

ХУУДАС

12

Нийтлэл:

Төрөөс хэрэгжүүлдэг эдийн засгийн бодлого

ХУУДАС

16

Инфографик:

Түүхий эд

ХУУДАС

18

Дэлхийн эдийн засаг:

Хүн бүрийн мэдүүштэй Эдийн засгийн 5 нобелийн шагнал

ХУУДАС

19

Санхүүгийн боловсрол:

М.Нургул: Улс эх орноо санхүүгийн боловсрол бүхий иргэдтэй, өндөр хөгжилтэй улс орон болгохын төлөө хувь нэмрээ оруулцгаая

ХУУДАС

23

Монголбанкны түүх:

Монголын эстрад хөгжмийн урсгалын түүхэнд өвөрмөц өнгө нэмсэн "Эрдэнэс" хамтлаг

ХУУДАС

25

Банкир:

Б.Тулга: Үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь үндэсний стратеги, тогтвортой бодлогоос эхэлнэ

ХУУДАС

29

Нийтлэл:

Азийн тогтвортой өсөлт, тулгарч буй сорилтууд

ХУУДАС

32

Бодлого-Шийдвэр:

Мөнгөний бодлогын мэдэгдэл Бодлогын хүүг хэвээр хадгалах тухай

ХУУДАС

34

Уралдаан-Тэмцээн:

Ачигчийн буруугаас гаардаг инфляцийг аргалах арга, чарга нь юу вэ?

ХУУДАС

35

“Мөнгөний бодлогын 2018 оны үндсэн чиглэл”-ийн төсөлд санал авах хэлэлцүүлэг болов



Монголбанк “Мөнгөний бодлогын 2018 оны үндсэн чиглэл” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг 2017.09.25-ны өдөр зохион байгууллаа. Нээлттэй хэлэлцүүлэгт эрдэмтэн судлаачид, их сургуулийн багш нар, олон улсын байгууллагын шинжээчид, санхүүгийн зах зээлийн мэргэжилтнүүд, оюутнууд болон хэвлэл мэдээллийн байгууллагууд оролцсон бөгөөд мөнгөний бодлогын баримт бичигт тусгах санал хүсэлтээ илэрхийллээ. Тус баримт бичгийг УИХ-д өргөн барихын өмнө ийнхүү мэргэжилтнүүдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, санал бодлыг нь сонссоноор мөнгөний бодлогын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Улаанбаатар хотын 9 дүүргийн сургагч багш нарын сургалт болов

Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанк, “Бичил санхүүгийн хөгжлийн сан” хамтран Улаанбаатар хотын 9 дүүргийн “Насан туршийн боловсролын төв”-ийн багш нарыг “Сургагч багш” бэлтгэх хөтөлбөрт хамруулан сургалтыг 2017 оны 09 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтанд нийт 40 багш хамрагдаж, зорилтот бүлгүүдэд чиглэсэн санхүүгийн мэдлэгийг хэрхэн олгох тухай заах аргад суралцлаа. Санхүүгийн боловсрол олгох сургалт нь иргэн бүрт хүрэх бөгөөд өрхийн санхүүгээ зөв удирдах, орлогоо өсгөх, санхүү, залилангийн гэмт хэрэг ба эрсдэлээс өөрийгөө хэрхэн хамгаалах зэрэг олон төрлийн мэдлэг олгох юм.



Монголбанкинд тушаасан алтны хэмжээ 10 хувиар өссөн байна



Монголбанкны алт худалдан авалтын дүнг 2017 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн байдлаар авч үзэхэд 15.1 тоннд хүрээд байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 тонноор өссөн дүн юм. Энэ хугацаанд 182 иргэн, 106 аж ахуйн нэгж алт тушаажээ.

Монголбанк алтны арилжааг улсдаа төвлөрүүлэх бодлого барьж байгаа бөгөөд энэ хүрээнд олон нийтийг мэдээллээр хангахад анхаарч ажиллаж байна. Тиймээс “Монгол алт” аяныг зарлан хэрэгжүүлж, бичил уурхайчид, аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн сургалт уулзалтуудыг тогтмол хийж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Говийн иргэд Төв банкны тухай мэдлэгээ дээшлүүлээ

Монголбанкны Говийн бүсийн удирдах ажилтнуудын зөвлөгөөн Өмнөговь аймгийн Даланзадгад суманд 2017.09.20-ноос 23-ны өдрүүдэд боллоо. Зөвлөгөөний үеэр Өмнөговь аймгийн Засаг Даргын Тамгын Газрын ажилтнууд болон ЕБСургуулийн сурагчдад зориулж “Дэлхийн эдийн засгийн орчин, түүхий эдийн мэдээ”, “Төв банк гэж юу вэ?”, “Зээлийн мэдээллийн сан”, “Монгол Улсын хөрөнгийн зах зээл” зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж, мэдээлэл өгөв.



“Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал” сэдэвт түүвэр судалгааны үр дүнг танилцууллаа



Монголбанкны Судалгаа Статистикийн Газар “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал” сэдэвт түүвэр судалгааныхаа үр дүнг олон нийтэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн асуудлыг судалсан сүүлийн жилүүдийн судалгааны үр дүнгүүд ерөнхийдөө адил хүндрэл бэрхшээлийг нэрлэж байна. Энэ нь нэг талаас эдгээр хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэхэд бодлогын хэрэгжилт хангалтгүй байгааг илтгэж байна. Тиймээс үүсч буй бэрхшээл, шийдвэрлэвэл зохих арга хэмжээг судалгааны түвшинд дүгнэлт гаргаад орхих бус бодлогын баримт бичигт тусгаж, шийдвэрлүүлэх нь тулгамдаж буй гол асуудал болохыг хөндөж байв.

“Дунд шатны эдийн засгийн загварчлал ба төсөөлөл” сэдэвт сургалт болов

“Дунд шатны эдийн засгийн загварчлал ба төсөөлөл” сэдэвт Зүүн өмнөд Азийн төв банкуудын төв (The SEACEN Centre) болон Японы төв банк (BoJ)-ны хамтарсан сургалтыг Монголбанк зохион байгуулж байна. Сургалт 2017.10.01-06 өдрүүдэд Улаанбаатар хотноо болох бөгөөд Азийн 12 орны төв банкны эдийн засгийн судалгаа, төсөөлөл дээр ажилладаг 31 мэргэжилтэн хамрагдаж байна. Хичээлийг Зүүн өмнөд Азийн төв банкуудын төв болон Японы төв банкны экспертүүд заах бөгөөд, төв банкууд бодлогын шинжилгээ, симуляци, төсөөлөл хийхэд ашиглагддаг эмпирик загваруудыг зохиох, ашиглахад шаардлагатай арга, техникүүдийг эзэмшүүлэхэд чиглэгдэж байна.



Бэлтгэсэн: Д.Ариунаа (ОНБМТ-ийн ахлах мэргэжилтэн)



МЭРГЭЖИЛ: Эрх зүйч, Хуульч

2008 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч, бакалавр

2013 онд Тайландын Вант Улсын Таммасатын Их Сургуулийг Олон Улсын Харилцааны магистр зэрэгтэй төгссөн.

АЖЛЫН ТУРШЛАГА:

2008–2010– Монголбанк, Тамгын газар хуулийн мэргэжилтэн

2014–2017.3– Монголбанк, Хууль эрх зүйн газар, мэргэжилтэн

2017.3–2017.8 Монголбанк, Хууль эрх зүйн газар, ахлах мэргэжилтэн

2017.8– Монголбанк, Хууль эрх зүйн газар, Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал

ГИШҮҮНЧЛЭЛ: Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч

Б.ЭРДЭНЭХУЯГ: ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТӨӨР МОНГОЛБАНКНЫ БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТҮВШИН 80 ХУВЬД ХҮРНЭ

Монголбанкны Хууль, эрх зүйн газрын Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал Б.Эрдэнэхуягтай ярилцлаа.

■ **Монголбанкнаас Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, хуулийн төслийг боловсруулаад байгаа. Хуулийн төслийн голлох үзэл баримтлалын талаар ярилцлагаа эхэлье?**

-Төв банкны бие даасан, хараат бус байдал тухайн улс орны эдийн засгийн тогтвортой өсөлт, санхүүгийн тогтвортой байдалд голлох үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хөгжил нь нэгдүгээрт бодлого, хоёрдугаарт бодлогыг хэрэгжүүлэгч механизм, гуравдугаарт бодлогыг хүлээж авч байгаа дэд бүтэц гэсэн гурван тулгууртай гэж үзвэл нэг, хоёрдугаар хэсэгт нь байгаа бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх институци нь Төв банк юм. Тэгэхээр энэ байгууллагын бие даасан, хараат бус байдал маш чухал. Хараат бус,

бие даасан байдлыг сайжруулах явдал 1970-аад оноос хойш дэлхий даяарх Төв банкуудын үйл ажиллагаанд чухлаар тавигдах болсон. Төв банкны бие даасан, хараат бус байдал нь гурван үндсэн зүйлээс бүрддэг. Нэгдүгээрт, байгууллагын бие даасан байдал буюу бусдаас хараат бус, нөлөөгүйгээр шийдвэр гаргах, үйл ажиллагаагаа явуулах. Хоёрдугаарт, хариуцлагатай байдал. Гуравдугаарт ил тод байдал юм. Хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлох зорилгоор хийсэн судалгаагаар Монгол Улсын Төв банкны хувьд байгууллагын хараат бус байдал сул байна гэх үр дүн гарсан. Үүнийг хууль, эрх зүйн үүднээс засч, сайжруулах явдал нь Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үндсэн үзэл баримтлал болсон юм.



■ Тэгвэл энэ үзэл баримтлалын хүрээнд Төв банкны хуульд голлох ямар өөрчлөлтүүд оруулж байгаа вэ?

-Нэгдүгээрт, Монголбанкны зорилтыг тодорхой болгох. Энэ нь үнийн түвшний тогтвортой байдлыг хангах замаар төгрөгийн худалдан авах чадварыг хамгаалах зорилтыг тодорхой болгож байна. Мөн санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлийн зорилтыг тодорхой болгож, энэ хүрээнд хэрэгжүүлэх макро зохистой бодлого, банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг нэмэгдүүлэн тусгаж байна. Хоёрдугаарт, Төв банкны удирдлагын хараат бус байдал, Төв банкны удирдлагыг албан тушаалд томилох, чөлөөлөх шалгуурыг тодорхой болгох шаардлага юм. Өөрөөр хэлбэл, хуульд тусгайлан заагаагүй аль нэгэн ашиг сонирхлыг төлөөлсөн бусад этгээдээс шалтгаалахгүйгээр чөлөөлөх, томилох харилцаа нь маш тодорхой, объектив байдлаар ханддаг

болгож хуульчилна. Дараагийн асуудал нь Монгол Улс бусад дэлхийн улс орнуудын Төв банкуудын жишгийн дагуу бодлогын шийдвэр гаргах тогтолцоо, шийдвэрийг хэрэгжүүлэх механизмыг ялгаатай авч үзэж, хуульчлах юм. Ямар нэгэн шийдвэр гарахад хамтын удирдлагын зарчмыг нэвтрүүлэх буюу олонхийн саналаар гаргадаг байх механизм руу шилжинэ. Одоогийн хуулиар бол Монголбанкны Ерөнхийлөгч Монголбанкийг толгойлон удирдаж, бодлого боловсруулах болон хэрэгжүүлэхтэй холбоотой бүх шийдвэрийг гаргадаг. Үүнтэй холбогдуулаад, Мөнгөний бодлогын хороо, Хяналт шалгалтын зөвлөл болон Монголбанкны бусад асуудлыг шийддэг Удирдах зөвлөлтэй байх бүтцийн өөрчлөлт хийх юм. Дараагийн нэг асуудал бол Засгийн газраас хараат бус байх талын зохицуулалтууд. Ялангуяа төсвийн шинжтэй үйл ажиллагааг хязгаарлах, Монголбанкны үндсэн үйл ажиллагааг тодорхой болгохыг хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд зорьж

байна. Эцэст нь нэмж хэлэхэд 1996 онд батлагдсан Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн зарим зохицуулалтыг нь өнөө цагийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, шинээр томъёолох шаардлагатай болсон.

■ Хуульд өөрчлөлт оруулснаар Төв банкны хараат бус байдлын түвшин хэрхэн өөрчлөгдөнө гэж харж байгаа вэ? Тооцоо, судалгаа бий юу?

-Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд өөрчлөлт оруулах төсөл боловсруулах ажлын хэсгийн судалгааны ажил, ОУВС-гаас хийсэн судалгаа, бусад дотоодын судалгаануудаас үзэхэд Монгол Улсын Төв банкны бие даасан, хараат бус байдлын түвшин бусад улс оронтой харьцуулахад 100 хувь гэж үзвэл 50-60 орчим хувьтай байна. Хуульд өөрчлөлт оруулснаар бие даасан, хараат бус байдлын түвшин 80 орчим хувьд хүрнэ гэсэн зорилт, төсөөлөлтэй байна.

■ Төв банкны Ерөнхийлөгчийг томилох, чөлөөлөх асуудлыг тодорхой болгоно гэж байна. Үүнийг дэлгэрэнгүй тодруулна уу?

-Одоогийн хуулиар бол жишээ нь Монголбанкны Ерөнхийлөгч ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн бол чөлөөлөх нэг үндэслэл болохоор байгаа. Гэтэл ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн гэдгийг хэн тодорхойлох вэ, ямар тохиолдолд хангалтгүй гэж үзэх вэ гэдэг асуудал тодорхойгүй. Түүнчлэн “Эрүүл мэндийн шалтгаанаас үүдэн ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон” гэдэг өргөдөл гаргасан бол гэж байгаа. Гэтэл энэ нь эдгэшгүй өвчин тусах юм уу, эсвэл бие нь бага зэрэг өвдөхөөрөө ажлаасаа чөлөөлөгдөх ч юм уу. Үүнийг бас л тодорхой тусгаж өгөөгүй. Тэгэхээр хуулийн өөрчлөлтөөр ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн гэж байгаа бол тэрнээс нь болж улс оронд, Монголбанкинд бодит хохирол учирсан, тэр хохирлыг нь шүүхээс тогтоосон, энэ нь тухайн хүний санаатай, гэм буруутай үйл ажиллагаанаас болсон гэж үзсэн тохиолдолд чөлөөлөх үндэслэл болно. Түүнчлэн эрүүл мэндийн шалтгаанаас гэж байгаа бол тухайн хүний бие, эрүүл мэндийн байдлыг эмнэлгийн байгууллагаас тогтоосон гэх зэргээр нотлох баримт, нотолгоотой үед чөлөөлөх асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэж байхаар хуулийн өөрчлөлтөд тусгаж өгч байгаа.

■ Одоогийн хуулиар Төв банкны Ерөнхийлөгчийг чөлөөлөх саналыг зөвхөн УИХ-ын дарга санаачилсан үед УИХ-аар хэлэлцэж, шийдвэрлэдэг. Энэ нөхцөл байдал тэгвэл өөрчлөгдөх үү?

-Чөлөөлөх саналыг хэн нэгэн хүн, албан тушаалтны үзэмжээр бус тодорхой бодит нөхцөл, үндэслэл бүрдсэн үед чөлөөлөх бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэхээр хуулийн төсөлд тусгаад байна.

■ Мөнгөний Бодлогын Зөвлөлийн үйл ажиллагааг хуульчилна гэж байна. Мөнгөний Бодлогын Зөвлөл одоогийн хуулийн хүрээнд ч бас ажиллаж байгаа. Нэмж, хуульчилснаар ямар давуу тал бий болох вэ?

- Мөнгөний Бодлогын Зөвлөлийг Төв банкны тухай хуулийн 27-д “Монголбанкны Ерөнхийлөгчийн дэргэд зөвлөх эрхтэй зөвлөл байж болно” гэсний дагуу ажиллаж, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх гол шийдвэрүүдийг гаргаад явж байгаа. Гэвч хуулийн дагуу бол энэ зөвлөл нь эцсийн шийдвэр гаргадаггүй, харин Монголбанкны Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ дагуу эцсийн шийдвэр гаргадаг. Тэгэхээр энэхүү зөвлөх эрхтэй институцийн эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлж хамтын удирдлагын зарчимд суурилсан, олонхийн саналаар санал хурааж, шийдвэр гаргадаг институци болгохоор тусгасан. Өөрөөр хэлбэл, Мөнгөний Бодлогын Хорооноос тогтоол хэлбэртэй шийдвэр гардаг, түүнийгээ олон нийтэд мэдээлдэг болно.

■ Хуулийн төсөл батлагдах хугацааны талаар тодорхой хүлээлт байна уу? Намрын чуулганаар өргөн баригдах байх?

- УИХ-ын тогтоол, түүнийг хэрэгжүүлэх тухай Монголбанкны төлөвлөгөөнд заасны дагуу хуулийн төслийг УИХ-ын энэ намрын чуулганаар хэлэлцүүлж, батлуулахаар ажиллаж байна. Мөн ОУВС-тай тохиролцсон хөтөлбөрт 2017 оны 11-р сард багтаан хуулийн төслийг өргөн барьж, 2018 оны гуравдугаар сар гэхэд батлагдсан байх талаар бодлогын баримт бичигт туссан. Гэхдээ бид энэ хугацаанаас өмнө батлуулах зорилттой ажиллаж байна.

Ярилцсанд баярлалаа.

Улаанбаатар хотын инфляци 08 дугаар сарын байдлаар

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн жилийн инфляци **2017 оны 08 дугаар сард** улсын хэмжээнд **5%-д**, Улаанбаатар хотын хэмжээнд **5.4%-д** хүрлээ.



Инфляци, түүний бүрэлдэхүүн



Улаанбаатар хот
инфляци
/жилийн/



МАНЖИЙН НОЁРХОЛЫН ҮЕИЙН МОНГОЛ УЛСЫН ЦААСАН МӨНГӨН ТЭМДЭГТ

Монгол улс нь Манж Чин улсын харъяанд орсноор барааг бараагаар солих наймааны хэлбэр давамгайлж, гүйлгээний мөнгөний үүргийг таван хошуу мал болон, цай, хадаг зэрэг бараа орлож байжээ. Монгол оронд Хятадын худалдаа наймаа өргөн нэвтэрч тэдний зоосон мөнгө, жингийн мөнгө, мөнгөн зоос, ембүү, пүүсүүдийн пяз болон цайны үнэлгээт тийз зэрэг олон төрлийн мөнгөн дэвсгэрт хэрэглэгдэж иржээ. Энэ үед хэдийгээр Монгол оронд нийт улс орныг хамарсан үндэсний мөнгөн тэмдэгт байхгүй байсан боловч зарим нэг хошуу, томоохон хутагтууд, сүм хийдийн жас сангаас өөрийн харьяа орон нутаг, шавийн газар хүчин төгөлдөр мөрддөг, тодорхой нэгж үнэлгээтэй, янз бүрийн нэртэй гүйлгээний хэрэгслүүдийг гүйлгээнд гаргаж байжээ. Одоогоор Баянхонгор, Өмнөговь, Завхан, Говь-Алтай аймгууд болон Нийслэл Хүрээнд шар цай, их сангийн тийз, зэд таван фун, нэг цэн, гурван зуун зоосны зэрэг цаасан дэвсгэртүүдийг гүйлгээнд тодорхой хэмжээнд ашиглаж байсан нь биетээрээ олдоод байна.

Их сангийн тийз хэмээх мөнгөн тэмдэгт

Энэхүү Их сангийн тийз нэртэй мөнгөн тэмдэгтийг Чин сүсэгт Номун ханы хүрээний гэгээний сангаас (Одоогийн Баянхонгор аймгийн Мандал сум) өөрийн харьяа шавийн нутагт гүйлгэхээр гаргажээ.

Энэ мөнгөн тэмдэгт нь нэг шар цай, арван шар цай гэсэн хоёр янзын үнэлгээтэй дэвсгэртээр гарсан байна. Мөнгөн тэмдэгтийг зузаавтар орос цаасан дээр хээтэй давхар хүрээтэй, гол хэсэгт хас хээтэй, түүний дөрвөн буланд нь шороо, ус, агаар, гал гэсэн дөрвөн махбодийн билэгдэл дүрсэлсэн дүрс зэргийг модон бар дээр сийлж, тусгай найрлагаар гаргаж авсан ургамлын гаралтай шаравтар ногоон будгаар барласан байна.

Энэ мөнгөн тэмдэгтийн нэгж болох шар цай нь уудаг зузаан цайг 60 хуваасны нэг хэсгийг хэлдэг байжээ. Энэ нь шар цайг бас гүйлгээнд хэрэглэж байсныг давхар баталж байгаа юм.

Дэвсгэртийг эхлээд барлаад дараа нь бийрээр нөхөж Их сангийн тийз болон нэг ба арван шар цай гэж нөхөж бичдэг байсан нь тухайн бичээчийн гарын бичиглэл, тиг зэргээс шалтгаалж, одоогоор олдсон дэвсгэртүүд нь бүгд өөр хоорондоо ялгаатай байгаа нь ихээхэн онцлогтой байна.

Энэхүү мөнгөн тэмдэгт нь тухайн үеийн Монгол улсын засаг захиргааны нэгж болон сүм хийдийн тухай мэдээлэл өгөх түүхэн ач холбогдолтойгоос гадна, дүрслэх урлагийн болон монгол хэл бичгийн дурсгал зэргийг

харуулсан банк, санхүүгийн салбарын 100 гаруй жилийн өмнөх гүйлгээний хэрэгслийн хувьд түүхийн хосгүй үнэт өв юм. Он цагийн уртад цөөхөн хэдэн ширхэг нь элэгдэж хуучран өнөөг хүрсэн нь Монголын зоос судлаач, цуглуулагч нарын цуглуулганд байгаа нэн ховор мөнгөн тэмдэгтийн нэг юм..



1 шар цайны үнэлгээт Их сангийн Тийз хэмээх мөнгөн тэмдэгт. 110x80 мм

Дэвсгэртийн гол хэсэгт монгол бичгээр хар өнгийн бэхтэй бийрээр “Их сангийн тийз”, түүний баруун гар талд “Нэг шар цай” гэж бичсэн байх ба дэвсгэртийн төв хэсэгт төвд дөрвөлжин эвхмэл үсэгтэй, дөрвөлжин улаан тамга дарж баталгаажуулжээ. Нэг шар цайны үнэлгээт дэвсгэртийн ар тал нь цулгуй байна.



10 шар цайны үнэлгээт Их сангийн Тийз хэмээх мөнгөн тэмдэгт. 110x80 мм

Дэвсгэртийн гол хэсэгт монгол бичгээр хар өнгийн бэхтэй бийрээр “Их сангийн тийз”, түүний зүүн гар талд “Арван шар цай” гэж бичсэн байх ба дэвсгэртийн төв хэсэгт төвд дөрвөлжин эвхмэл үсэгтэй, дөрвөлжин улаан тамга дарж баталгаажуулжээ. Арван шар цайны үнэлгээт дэвсгэртийн ар талд нэмэлт жижиг улаан тамга дарж баталгаажуулсан байна.

Монголын зоос цуглуулагчдын холбоотой хамтран бэлтгэв



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН ХУРЛААС ... 2017.09.15

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2017.09.15-нд хуралдаж, бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Мөнгөний бодлогын мэдэгдлийг хүргэх хэвлэлийн бага хурлын асуулт, хариултыг хүргэж байна.

Асуулт:

Мөнгөний бодлогын хүүг хэвээр хадгалах шийдвэрийг гаргахад голлон нөлөөлсөн хүчин зүйл юу вэ? Хүүг бууруулах

боломж байсан уу?

Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа:

2017 он гарсаар манай экспортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг дагаад экспортын хэмжээ нэмэгдсэн. Үүнд хамгийн том жин дарж байгаа нь нүүрсний экспорт. Эхний хагас жилийн байдлаар нийт 1.2 тэрбум ам.долларын экспорт хийсэн нь өнгөрсөн оны нийт экспортын хэмжээнээс

давсан үзүүлэлт болж байгаа. Уул уурхайн салбарт гарч буй эерэг үзүүлэлт нь дотоодын эдийн засагт худалдаа, тээвэр, зэсийн бус уул уурхайн салбар, худалдааны эргэлт, татварын өсөлт зэргээр дамжин эерэгээр нөлөөлж байна. Түүнчлэн эдийн засгийн нийт хэрэглээ талаас нь харвал хөрөнгө оруулалтын түвшин нэмэгдэж, энэ нь хөдөлмөрийн зах дээр эерэг нөлөө үзүүлж эхэлсэн. Өөрөөр хэлбэл,



худалдаа, уул уурхайн салбарт ажил эрхлэлт нэмэгдэж байгаа нь энэ улиралд өрхийн орлогын түвшин нэмэгдэхэд нөлөөллөө. Орлогын өсөлтийг дагаад өрхүүдийн хэрэглээ нэмэгдсэн нь эдийн засагт эерэгээр нөлөөлж байгаа. Энэ бүгд нь санхүүгийн зах дээр банкуудын зээлийн эх үүсвэр буюу харилцах, хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлсэн. Шинээр олгосон зээлийн бүтцийг харвал уул уурхайн салбар, өрхийн хэрэглээний зээл дээр нэлээд хэмжээний өсөлт ажиглагдлаа. Нийт дүндээ шинээр гарч байгаа зээлийн өсөлт болон Засгийн газрын банкны системээс

авч байгаа зээлийн нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлтийн түвшин жилийн өмнөхөөс 20 орчим хувиар өссөн үр дүн харагдаж байна.

Үүнээс гадна эдийн засагт хүлээлт оны эхний хагаст нэлээд сайжирсан. Үүнтэй уялдаад санхүүгийн зах зээл дээр төгрөгт итгэх итгэл нэмэгдэж, эх үүсвэрийн өртөг буурсан. Энэ нь хадгаламжийн хүү аажмаар буурч байгаагаас харагдаж байна. Дээрээс нь Засгийн Газрын Үнэт Цаасны хүү буюу эрсдэлгүй өгөөж 5-7 нэгж хувиар буурсан байна. Ялангуяа нэг жил хүртэлх хугацаатай үнэт цаасны хүү буурч байгаа нь улсын төсөвт эерэгээр нөлөөлж байна. Засгийн газрын үнэт цаасны хүү нь санхүүгийн зах зээл дээрх бусад хүүгийн жишиг хүү болдог. Энэ хүү буурч байгаа нь санхүүгийн зах зээл дээр эх үүсвэрийн өртөг буурахад нөлөөлж байна.

Ийм эерэг өөрчлөлтүүд гарсан боловч инфляцийн төсөөллийг харвал энэ оны төгсгөлд 7 орчим хувь, ирэх онд 8 хувьд байхаар байна. Энэ нь өмнөх бодлогын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж байсан үеэс буурсан үзүүлэлт. Тухайн үед инфляцийн төсөөллийг хийхэд шатахууны үнэ долоодугаар сараас өснө, сургалтын төлбөр мөн өсөх байх гэж хүлээж байсан. Мөн махны үнийн өсөлтийг өндөр байх болов уу гэж харж байсан ч бодит гүйцэтгэлээ эдгээр үзүүлэлтүүд буурсан нь инфляцийн төсөөллийг бууруулахад нөлөөллөө.

Бодлогын хүүг хэвээр хадгалсан дараагийн үндэслэл нь өмнө нь гаргасан бодлогын шийдвэрийн үр дүнг хэрхэн гарахыг хүлээх шаардлага байна. Хэдийгээр хадгаламжийн хүү буурч байгаа

ч зээлийн хүү тогтвортой байгаа. Цаашид бодлогын хүүгийн түвшин зээлийн хүүд хэрхэн нөлөөлөх нь вэ гэдэг хүчин зүйл бий. Хоёрдугаарт, цаашдаа улсын төсөв ямар байдлаар өргөн баригдах, шинээр байгуулагдах Засгийн газрын төсвийн бодлого ямар байх вэ гэдгийг хүлээх шаардлагатай байна. Тийм учраас бодлогын хүүг энэ удаад хэвээр хадгалах шийдвэр гаргасан.

Асуулт:

Засгийн газар огцорсонтой холбоотойгоор ОУВС-гаас ирэх санхүүжилт хойшилсон гэх мэдээлэл гарч байгаа. Энэ талаар тодорхой мэдээлэл өгөхгүй юу?

Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа:

-ОУВС-гийн ажлын хэсэг хөтөлбөрийнхөө үнэлгээг хоёрдугаар улирлын байдлаар гүйцэтгэсэн байгаа. Энэ үнэлгээгээр зорилтот ажлууд бүгд хугацаандаа хийгдсэн гэх дүгнэлт гарсан. Ажлын хэсэг дүгнэлтээ есдүгээр сарын 25-нд ОУВС-гийн захирлуудын зөвлөлийн хуралд танилцуулах байсан. Дүгнэлтийг танилцуулах энэ хурал хойшилсон. Засгийн газар огцорсонтой холбоотойгоор ОУВС-гийнхан ямар тайлбар хийж байгаа вэ гэхээр "Шинээр бүрэлдэх Засгийн газартай бид уулзанаа" гэсэн байгаа. Уулзахдаа юуг тодруулах вэ гэхээр "ОУВС-тай тохирсон бодлогын арга хэмжээнүүд цаашдаа тогтвортой хэрэгжих үү" гэдгийг тодруулж байж, үнэлгээгээ хэлэлцэнэ гэдэг мэдээллийг өгсөн байгаа.

Асуулт:

Арилжааны банкуудад активын чанарын үнэлгээ хийгдэж байгаа. Энэ ажлын явц ямар шатандаа байна вэ?

Судалгаа статистикийн газрын захирал Д.Ган-Очир:

-Активын чанарын үнэлгээ эхлээд гурав дахь долоо хоногтоо орсон байна. Энэ үнэлгээг хийхдээ мэдээж иж бүрэн буюу активынх нь бодит, биет үнэлгээ ямар байна вэ, зээлийн материалууд нь ямар байна вэ гэх зэрэг тодорхой шат дараатайгаар хийгдэж байгаа. Бүх процесс төлөвлөгөөнийхөө дагуу явж байгаа бөгөөд гүйцэтгэгч компанитай хийсэн гэрээний дагуу арваннэгдүгээр сарын 30-ны өдөр гэхэд эхний үнэлгээнийхээ тайланг өгнө гэсэн байгаа. Тэгэхээр арваннэгдүгээр сарын 30-наас тайлан мэдээ гараад, үнэлгээ нь олон нийтэд хүрнэ гэж ойлгож болно.

Асуулт:

Чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үзүүлэлт бага зэрэг буурсан шалтгаан юу вэ?

Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа: -Зээлийн өсөлтийг харвал наймдугаар сарын байдлаар 7 орчим хувь байна. Ерөнхийдөө уул уурхайн салбар дээр нэлээд том зээлийн өсөлт гарсан. Нөгөө талдаа өрхүүдийн

хэрэглээний шинж чанартай зээлийн өсөлт томоохон жин дарж байгаа. Уул уурхайн салбарт гарч байгаа зээлийн өсөлт чанаргүй зээлд эерэгээр нөлөөлөх хандлага байна. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарт байсан чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн дүн хоёрдугаар улиралд нэлээд хэмжээгээр буурсан.

Асуулт:

Ипотекийн зээл хэвийн олгогдож байгаа юу. Он гарснаас хойш Монголбанкнаас хэдий хэмжээний санхүүжилтийг гаргаад байна вэ?

Мөнгөний бодлогын газрын Б.Баярдаваа:

-Ипотекийн зээлийн тухайд 2016 оны төгсгөлөөс Монголбанкны эзэмшиж буй ипотекийн зээлээр баталгаажсан бондын эргэн төлөлтөөр санхүүжүүлж байгаа. 2017 оны тавдугаар сар хүртэл үндсэн төлбөр болон купоны төлбөрийг хоёуланг нь зээлийн эх үүсвэр болгож гаргасан. Энэ нь дунджаар сард 25 орчим тэрбум төгрөгийн эх үүсвэр байсан. 2017 оны тавдугаар сараас эхлээд ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны санхүүжүүлэх дүнгийн хэмжээ бол зөвхөн үндсэн төлбөрөөр тодорхойлогдож эхэлсэн. Энэ нь 16 орчим тэрбум төгрөг. Үлдсэн хэсгийг Засгийн газраас санхүүжүүлэхээр болж,

төсөвт 111 тэрбум төгрөг суугдсан. Наймдугаар сарын байдлаар дээрх төсвийн санхүүжилтээс 71 тэрбум төгрөг нь санхүүжилтэд гарсан. Оны сүүлийн хагаст Засгийн газраас 40 тэрбум төгрөг, Монголбанкнаас сар бүр 16 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэнэ. Жилийн дүнгээрээ харвал ипотекийн зээлийн нийт санхүүжилт энэ онд 340-350 тэрбум төгрөг байгаа.

Асуулт:

2018 оны төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийг удахгүй УИХ-аар хэлэлцүүлэх ёстой. Төслийг боловсруулах үйл явцын талаар мэдээлэл өгнө үү?

Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа:

-Төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн төслийг Мөнгөний бодлогын зөвлөл болон Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцээд, дэмжсэн. Үүнээс хойш төсөл эцсийн найруулгадаа шилжиж байна. Эцсийн найруулгыг хийх явцад есдүгээр сарын сүүлээр бид төслийг олон нийт, мэргэжлийн хүрээнийхнээр хэлэлцүүлж, саналыг нь авна. Төслийг Захирлуудын зөвлөл, Мөнгөний бодлогын зөвлөлөөр хэлэлцүүлэхээс өмнө Засгийн газар болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж, саналыг нь авсан байгаа.



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

**ЗАРЛИГААР ӨРГӨМЖЛӨГДСӨН
ШАШНЫГ МАНДУУЛАХ, АМЬТНЫГ
ЖАРГУУЛАГЧ ЖАВЗАНДАМБА
ЛАМЫН АЛТАН ТАМГА**
ХОСГҮЙ ҮНЭТ
1875 он
Жин: 7414.0 гр
Өндөр: 6 см,
11.2 x 11.2 x 3.5 см
Алт цутгамал



Засгийн газрын 2010 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 103 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар Жавзандамба хутагтын алтан тамгыг Хосгүй үнэт дурсгалт зүйлсийн жагсаалтанд бүртгэн, 70 тоот гэрчилгээ олгосон байна.

Тамганд Монгол, Манж, Түвэд хэлээр “Зарлигаар өргөмжлөгдсөн шашныг мандуулах, амьтныг жаргуулагч Жавзандамба ламын тамга” гэж бичсэн. Аливаа үйлс сэтгэлчилэн бүтэх норов эрдэнийн дүрсээр тамганы бариулыг үйлджээ. Тамган дээр ямар нэгэн бичиг үсэг болон тэмдэглэгээгүй ажээ.





ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛДЭГ ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Сангийн бодлого

Аливаа улс оронд нийгмийн сайн сайхан байдлыг хамгийн их байлгах зорилгоор 2 төрлийн эдийн засгийн бодлогыг төрөөс хэрэгжүүлдэг. Нэгт, засгийн газраас явуулж буй эдийн засгийн бодлого буюу сангийн бодлого юм. Сангийн бодлого нь иргэд компаниудын төлж буй татварын мөнгөөр бүрдэж буй улсын төсвөөр хэрэгждэг тул төсвийн бодлого ч гэж нэрлэгддэг. Жишээ нь ихэнх сургууль цэцэрлэгийн зардал, эмч цагдаа нарын цалин, улсын төсвөөр баригдаж буй зам гүүр, цахилгаан станц гэх мэт дэд бүтцийн томоохон ажлууд ч үүнд хамаарна. Нийгэмд зайлшгүй хэрэгтэй ч, хувийн хэвшил хэрэгжүүлэх боломжгүй ажлуудыг (цэрэг, цагдаа г.м.) санхүүжүүлэх нь сангийн бодлогын нэг үндсэн чиглэл болдог. Түүнчлэн, татварын бодлогоор дамжуулж эдийн засаг дахь бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл болон хэрэглээг зохистой түвшинд байлгах нь сангийн бодлогын гол үүрэг юм.

Эдийн засгийн идэвхжил удааширч, хямрал нүүрлэсэн үед засгийн газрууд төсвийн хэрэглээ, хөрөнгө оруулалтаа нэмэх замаар ажлын байр бий болгох, бараа үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгаа дэмжих үйл ажиллагааг явуулдаг. Харин эдийн засгийн үйл ажиллагаа идэвхтэй өрнөж, компаниуд өндөр ашигтай, татварын орлого сайн байвал засгийн газрууд мөнгөө хадгалж, ирээдүйд учирч магадгүй хүндрэлийн үед зарцуулах хуримтлалыг үүсгэх нь оновчтой алхам гэж үздэг. Ингэснээр ажлын байр хадгалагдах, эдийн засгийн өсөлт тогтвортой байх нөхцөл бүрддэг.

Мөнгөний бодлого

Төрөөс хэрэгжүүлж буй нөгөө нэг эдийн засгийн гол бодлого нь төв банкуудын хэрэгжүүлдэг мөнгөний бодлого юм. Мөнгөний бодлого нь үнийн тогтвортой байдал буюу инфляцийг нам дор, тогтвортой байлгахад чиглэдэг. Монгол Улсын төв банк болох Монголбанк нь инфляцийг 8%-аас дээшгүй байлгахыг зорьж ажилладаг.

Үнэ тогтвортой байх нь нэн түрүүнд бидний халаасанд буй мөнгөний худалдан авах чадвар буюу иргэдийн амьжиргаанд чухал нөлөөтэй. Түүнчлэн, компаниудын хувьд бараа үйлчилгээ үйлдвэрлэхэд шаардлагатай зүйлсийн үнэ, эсвэл борлуулж буй бүтээгдэхүүний үнэ нь ирээдүйд хэр тогтвортой байх вэ гэдэг чухал. Үнэ цаашид тогтвортой байх, таамаглаж болохуйц байвал бизнес эрхлэгчид илүү оновчтой бизнесийн төлөвлөгөө боловсруулж, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх боломж нэмэгдэнэ. Иймд, үнэ тогтвортой байх нь зах зээл дээр арилжаа наймаа, үйлдвэрлэл хэвийн явагдах үндэс суурь болдог.

Төв банкууд инфляцийг тогтвортой байлгахын тулд ашигладаг гол арга хэрэгсэл нь Бодлогын хүү юм. Бодлогын хүү нь арилжааны банкууд төв банкинд мөнгөө хадгалуулах хүү гэж ойлгож болно. Мөнгө хэвлэх эрхтэй төв банк хэзээд хадгалуулсан мөнгийг эргүүлж төлөх чадвартай гэдэг утгаараа улс орнуудад бодлогын хүүг эсдэлгүй хүү гэж ч нэрлэдэг. Энэхүү эрсдэлгүй хүүтэй харьцуулагдаж зах зээл дээрх бусад арилжааны хүү тогтдог учир бодлогын хүүг хөтөч



хүү гэж нэрлэх нь ч бий. Бодлогын хүү өндөр үед арилжааны банкууд эрсдэлтэй зээл гаргахын оронд төв банкинд мөнгөө найдвартай хадгалуулах, эсвэл зөвхөн өндөр хүү төлөх зээлдэгчид л арилжааны зээл гаргах нь түгээмэл. Улмаар эдийн засагт нийлүүлэгдэж буй мөнгөний эргэлт удааширдаг. Харин бодлогын хүү буурах үед банкууд мөнгөө төв банкинд хадгалуулснаас иргэд, компаниудад зээлэх нь ашигтай тул эдийн засаг руу орох мөнгөний урсгал нэмэгддэг. Ийнхүү төв банкууд бодлогын хүүг өөрчлөх замаар эдийн засагт эргэлдэж буй мөнгөний нийлүүлэлтийг удирдаж, эдийн засгийн идэвхжилд нөлөөлөхийг зорьдог.

Төсөв, мөнгөний бодлогын уялдаа

Иргэдийн орлого, амьжиргаа тогтвортой, эдийн засгийн орчин савлагаа багатай байснаар нийгмийн сайн сайхан байдал дээшилнэ эдийн засагчид гэж үздэг. Үүний тулд төрөөс хэрэгжүүлж буй төсөв болон мөнгөний бодлого нь хоорондоо уялдаатай байх, төв банк засгийн газартайгаа оновчтой хамтарч ажиллах нь чухал. Энэ нь нэг талаас эдийн засгийн хямралыг давж туулах, харин нөгөө талаас эдийн засаг хэт халахаас сэргийлэх боломжийг нэмэгдүүлж, ажилгүйдэл бага түвшинд, үнийн өсөлт нам дор бөгөөд тогтвортой, эдийн засгийн өсөлт тогтвортой байхад чухал ач холбогдолтой юм.

Гэхдээ энэ нь төсөв болон мөнгөний бодлого цуг байна гэсэн үг биш юм. Харин ч ихэнх улс орнууд энэхүү 2 бодлогыг тусад нь салгаж, засгийн газраасаа хараат бус төв банкт байхыг чухалчилдаг. Учир нь зарим


засгийн газрууд сонгогчдод таалагдах, улмаар дахин сонгогдохын тулд бэлэн мөнгө тараах, халамжийн хэт хавтгай бодлого явуулах тохиолдол бий. Гэхдээ татварын мөнгөөр бүрддэг улсын төсөв хязгаартай тул эдийн засагт хор уршигтай иймэрхүү бодлогуудыг үргэлж санхүүжүүлэх боломж тэр бүр үгүй. Харин засгийн газруудад мөнгө хэвлэх эрх нээлттэй үед энэ үйлдэл боломжтой тул эдийн засагтаа аюултай сөрөг үр дагавар үүсгэсэн тохиолдол дэлхийн түүхэнд цөөнгүй бий.

Иймд өнөөдөр ихэнх улс орнуудад мөнгө хэвлэх эрхийг улс төрөөс салган, бие даасан төв банкинд хариуцуулдаг болжээ. Ингэснээр үнийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн мөнгөний бодлогыг мэргэжлийн эдийн засагчид хэрэгжүүлэх боломжийг олгосон. Ардчилсан нийгэмд засгийн газрууд улстөрийн сонгуулиар сонгогдож, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлж байж л амжилт олдог бөгөөд зарим амлалтууд эдийн засагтаа тийм ч сайн үр дүн авчрах албагүй байдаг. Харин төв банк сонгогчдод таалагдах түр зурын бодлого явуулах бус, эдийн засгийг тогтвортой, эрүүл байлгахад чиглэсэн урт хугацааны бодлого явуулдаг мэргэжлийн байгууллага байх нь чухал гэдэг үзэл өнөөгийн жишиг болжээ.

Монголбанк,

Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ.ДОЛЛАРААР, 26/IX ӨДРИЙН БАЙДЛААР)



NOBEL PRIZE ECONOMICS



ХҮН БҮРИЙН МЭДҮҮШТЭЙ ЭДИЙН ЗАСГИЙН 5 НОБЕЛИЙН ШАГНАЛ

Орчуулга – Тойм

Эдийн засгийн ухаанд хувьсгал хийн, хүн төрөлхтний хөгжлийг нэг алхмаар урагшлуулсан нээлтүүдэд Алфред Нобелийн нэрэмжит шагналыг 1969 онд анх гардуулдаг болсноос хойш 44 удаагийн ёслолоор нийт 78 шагналтан тодроод байна. Тэр дундаас бидний өдөр тутмын амьдралд маш их хэрэг болох, хэвлэл мэдээллээр байнга яригддаг эдийн засгийн онолуудыг тоймлон хүргэж байна.

Нийтийн нөөцийг удирдах тухай (Management of Common Pool Resources)



2009 онд Элиноор Остром “нөөц баялгийн удирдлага, тэр дундаа нийтийн нөөцийн удирдлагын талаар хийсэн шинжилгээ”-нийхээ үр дүнд Нобелийн шагнал хүртсэнээр анхны Нобелийн шагналт эмэгтэй болсон юм. Түүний судалгааны ажлын гол үр дүн нь усны нөөц, зэрлэг амьтан, бэлчээр зэрэг хязгаарлагдмал нөөцийг хамтын өмчлөлийн хэлбэрээр оновчтой удирдаж болохыг нотолсонд оршдог. Тэрээр хүмүүс нийтийн нөөцийг хувааж ашиглах үед “Нийтийн

өмчийн эмгэнэл” заавал тохиолдох албагүй гэдгийг баталсан юм. Анх АНУ-ын экологич Хардины зохиосон тус онолоор бол олон хүн хамтарч эзэмших үед нийтийн нөөц хэт их ашиглагдсанаас болж шавхагдан, улмаар бүгд хохирч үлдэх тул төрийн эзэмшилд байлгах, эсвэл хувийн эзэмшилд хуваарилж өгөх нь зүйтэй гэж үздэг байв. “Нийтийн өмчийн эмгэнэл” нь нийтийн өмчийг ашиглах үед хувь хүмүүс өөрийн ашиг хонжоог хамгийн их байлгахыг зорьдог тул дараагийн хүнд ногдох ашгийг үлэмж хэмжээгээр бууруулдаг болохыг тайлбарладаг. Харин Остромын судалгаанд нийтийн нөөцийг ашиглаж байгаа этгээдүүд нь нэгнийгээ таньдаг, тухайн нөөцтэй газар нутгийн ойр хавьд амьдардаг бол төр засгийн оролцоо, хяналтгүйгээр нөөцийг үр ашигтайгаар удирдаж болохыг харуулжээ. Учир нь төр засаг болон хөндлөнгийн этгээдүүд нь тухайн газар нутгийн соёл, нөхцөл байдал, хэм хэмжээг сайн ойлгож мэдэрдэггүйн улмаас нийтийн нөөцийг зохимжтой ашиглаж, удирдахдаа тааруу байдаг байна. Харин тухайн газар нутагт оршин суудаг хүмүүс нь нөөц ашиглалтад хандахдаа өөртөө болон бусад оролцогч нарт өндөр хяналт тавьж, ёс дүрэм мөрдөж байгаа эсэх дээр анхаарч ажиллаж чаддаг байна.

Зан төлөвийн эдийн засаг (Behavioral Economics)



2002 оны Нобелийн шагналыг сэтгэл судлаач Даниел Канеманд "тодорхой бус нөхцөл байдалд хүний гаргадаг дүгнэлт, шийдвэрийн талаар судалж, сэтгэлзүйн ухааны мэдлэгийг эдийн засгийн ухаанд нэгтгэсэн" амжилтынх нь төлөө өгсөн юм.

Тэрээр ханамжаа хамгийн их байлгахын тулд хүмүүс үргэлж хувийн ашиг сонирхлоо хөөн, рациональ шийдвэр гаргах албагүй гэдгийг харуулснаар "хүн бол рациональ" гэж үздэг эдийн засгийн суурь ойлголтыг эвдсэн юм. Энэ нь зан төлөвийн санхүү, зан төлөвийн эдийн засгийн ухаан гэж нэрлэгдэх болсон шинэ салбарын хөгжилд чухал нөлөө үзүүлжээ. Канеман судалгаагаа Амос Тверскитэй хамтарч хийсэн боловч Тверски 1996 онд нас барсан учир шагналыг ганцаар хүртсэн байдаг.

Хүмүүсийн сэтгэхүйн алдаа нь буруу эргэцүүлэл хийн рациональ бус шийдвэр гаргах шалтгаан болдог гэдгийг эдгээр эрдэмтэд харуулсан юм. Тухайлбал, хүмүүс дүгнэлт хийхдээ тухайн асуудалд хамааралгүй мэдээлэл ашиглах ("Anchoring effect"), хэт өөдрөгөөр төлөвлөн тухайн ажилд шаардлагатай цагийг багаар тооцох ("Planning fallacy"), өөрөөс хамаарахгүй хүчин зүйлсийг удирдаж чадна гэж итгэх ("Illusion of control") зэрэг нь сэтгэхүйн алдаа юм. Канеман ба Тверскигийн бичсэн "Проспектийн онол: Эрсдэл дунд гаргах шийдвэрийг шинжлэх нь" судалгааны ажил нь өнөөдөр эдийн засгийн сэтгүүлүүдэд хамгийн ихээр ишлэгддэг бүтээл болжээ. Шагнал хүртсэн "Проспектийн онол" нь хүмүүс тодорхойгүй нөхцөл байдалд хэрхэн шийдвэр гаргадгийг тайлбарладаг. Хүмүүс логик бус харин сэтгэл хөдлөл, хандлага, үнэлэмж, дурсамж дээр үндэслэсэн иррациональ шийдвэр гаргах нь түгээмэл. Жишээ нь, хүмүүс бид хямд зүйл худалдаж авахдаа хэмнэхийг оролдож буй яг тэр мөнгөн дүнгээ үнэтэй зүйл худалдаж авах үедээ хэмнэхийг боддоггүй байна.

Түүнчлэн, Канеман болон Тверски нар хүмүүс ихэнхдээ магадлалын хуультай зөрчилтэй дүгнэлт хийх хандлагатай байдгийг ч харуулжээ. Тухайлбал нэг эмэгтэйд ялгаварлан гадуурхалтын талаар санаа

зовж явдаг гэж танилцуулаад, тухайн эмэгтэйд "Зүгээр л банкны теллер үү?", эсвэл "Феминист активист теллер үү?" гэж асуухад 2 дахь нь гэж хариулах хүн олон. Уул нь магадлалын онолоор бол тэр эмэгтэйд зүгээр л банкны теллер байх боломж нь хамаагүй өндөр юм.

Мэдээллийн тэгш бус байдал (Asymmetric Information)



2001 оны Нобелийн шагналыг Жорж Акерлоф, А.Майкл Спенс, Жозеф Э.Стиглиц нарт "зах зээл дээрх мэдээллийн тэгш бус байдлыг судалснаа төлөө" хүртсэн байна. Бодит байдал дээр мэдээллийн тэгш бус байдал буюу арилжаанд оролцогч 2 талын нэг нь илүү, харин нөгөө нь дутуу мэдээлэлтэй

байдаг тул төгс мэдээлэл дээр үндэслэсэн эдийн засгийн загвар алдаатай гэдгийг тэд харуулжээ.

Мэдээллийн тэгш бус байдлын талаарх ойлголт нь зах зээл хэрхэн ажилладаг механизмийг илүү нарийн тайлбарлахын зэрэгцээ, компаниудын мэдээлэл ил тод байх нь хэр зэрэг чухал болохыг бидэнд ойлгуулсан юм. Акерлофын хувьд, хуучин машины зах зээл дээр мэдээллийн тэгш бус байдал нь зах зээл дээр зөвхөн муу машин үлдэх шалтгаан болдгийг тайлбарласан байдаг. Зарах машиныхаа чанарыг сайн мэдэж буй худалдагч машинаа бага үнээр зарахгүй. Харин худалдан авагч чанарыг нь сайн мэдэхгүй машиныг өндөр үнээр авахгүй. Иймд зөвхөн бага үнээр зарагдах муу машин л зах дээр үлдэж, хийгдэх худалдааны цар хүрээ эрс хумигдах эрсдэлтэй. Үүнийг тайлбарласан "Нимбэгний зах зээл: Чанарын тодорхойгүй байдал ба зах зээлийн механизм" нэртэй судалгааны ажил нь Акерлофыг Нобелийн шагнал хамтран эзэмшигч болгосон юм.

Харин Спенсийн судалгаа нь зах зээл дээрх мэдээлэл сайтай оролцогчид бусаддаа мэдээллээ хэрхэн дамжуулах буюу дохио өгөх (сигнал) гэдэг сэдэв дээр төвлөрсөн. Жишээ нь, ажил хайж буй хүмүүс өөрийнхөө бүтээмжийн дохио болгож ажил олгогчдод боловсролын түвшнээ (диплом) үзүүлдэг. Компаниудын хувьд, хөрөнгө оруулагч нартаа тарааж буй ногдол ашиг нь ашигт ажиллагааны дохио гэж ойлгож болох юм.

Стиглиц болохоор даатгалын компаниуд хураамж (премиум) болон даатгалын тохиолдол гарах үед харилцагч өөрөө төлөх зардал (дидактибл) зэргийг ногдуулах замаар даатгуулагчдын хэн нь өндөр эрсдэл, их зардалтайг ялгах боломжтойг харуулсан.

Эдгээр ойлголтууд нь өнөөдөр бидний өдөр тутмын амьдралд байдаг ердийн зүйлс болсон хэдий ч, анх боловсруулагдаж байх үедээ хувьсгал хийсэн цоо шинэ санаанууд байсан юм.

Тоглоомын онол (Game Theory)



1994 оны эдийн засгийн Нобелийн шагналыг Жон Харсани, Жон Нэш, Рейнхард Зельтен нар тоглоомын онолд оруулсан чухал хувь нэмрийнхээ төлөө хүртсэн байна. Тэд хүмүүс хоорондын харилцан үйл хөдлөлийн стратегийг судалдаг "Тоглоомын онол"-ын нэг гол бүрэлдэхүүн болох "Харилцан

тохиролцоогүй тоглоом" буюу оролцогч талууд нь бие биенийхээ хийх үйлдлийг мэдэхгүй, зөвхөн таамаглал дээр суурилан өөрийн хариу үйлдлээ тооцоолох үед бий болдог үр дүнгийн талаар судалжээ.

Нэшийн оруулсан гол хувь нэмэр нь "Нэшийн тэнцвэр" гэж нэрлэгддэг бөгөөд 1950 онд Принстоны их сургуульд байхдаа бичсэн дипломын ажилд нь томъёологдсон онол юм. Ердөө 21 настайдаа бичсэн 27 хуудас энэхүү бүтээлд хоёр тоглогчтой тоглоом болон тэг нийлбэрт тоглоомын талаарх судалгааг өргөжүүлсэн юм. Хожим нь түүний судалгаан дээр тулгуурлаад Зельтен болон Харсани нар динамик стратеги, бүрэн бус мэдээлэлтэй үеийн тохиолдлыг нэмж судалснаар Мэдээллийн эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулжээ. Өдгөө тэдний судалгаа нь олигополь, өрсөлдөөн, фирмүүдийн үйл хөдлөл гэх мэт эдийн засгийн судалгаанд өргөн ашиглагддаг бөгөөд олон шинэ чиглэлийн судалгааны үндэс суурь нь болсон байна.

Нийтийн сонголтын онол (Public Choice Theory)



Жеймс М. Бьюкенен "Эдийн засгийн, улстөрийн шийдвэр гаргалтын онолд гэрээний болон хуулийн тулгуурыг хөгжүүлсэн" тул 1986 онд эдийн засгийн ухааны Нобелийн шагналыг хүртжээ. Төрийн өндөр албан тушаалтнууд (улс төрчид, эрх мэдэлтнүүд г.м.) хэрхэн шийдвэр гаргадгийг улс төрийн шинжлэх

ухаан, эдийн засгийн ухааны мэдлэгийг хавсарган тайлбарласан нь түүний гол хувь нэмэр байсан юм. Бьюкенен улстөрчид, бюрократууд нийтийн эрх ашгийн төлөө бус, харин яг л хувийн хэвшлийнхний нэгэн адил өөрийн ашиг сонирхлын төлөө зүтгэдэг гэдгийг харуулсан юм. Нийтийн сонголтын онолоо тэрээр "Романсгүй улстөр" гэж ч нэрлэдэг.

Улстөрийн процесс, хүний араншин, чөлөөт зах зээлийн талаарх Бьюкенений өнцгийг ашиглаад улстөрчдийн инсентив, сонирхлыг илүү сайн ойлгож, улмаар улстөрийн шийдвэрийн үр дүнг илүү сайн таамаглах бололцоотой юм. Тэгэхээр, нийтийн эрх ашигт нийцтэй, сайн үр дүнд хүргэх шийдвэр гардаг байхаар хайрцаг буюу дүрмүүдийг боловсруулах боломжийг бидэнд олгож буй.

Жишээ нь, засгийн газрын зарим зардалд хязгаар тавих заалтыг үндсэн хууль гэх мэт суурь дүрмэндээ оруулснаар, төсвийн алдагдлыг бууруулж татварын дарамтыг багасган улмаар нийтийн эрх ашгийг хамгаалах боломжтой. Учир нь төсвөөс санхүүжиж байгаа хөтөлбөрүүд сонгогчдоос оноо авах хэрэгсэл нь болдог учраас аливаа орны улстөрчид төсвийн зардлыг өсгөх, алдагдлыг ихэсгэх хандлагатай байдаг юм.

Бьюкенений Нобелийн шагнал хүртсэн энэхүү онолыг 1962 онд Г.Таллоктой хамтран хэвлүүлсэн "The Calculus of Consent: Logical Foundations of Constitutional Democracy" номноос унших боломжтой.

Эх сурвалж: Investopedia

Тоймлосон: Н.Батжин (Монголбанкны ОНБМТ)




Монгол Улсын Экспортын бүтэц




2017 оны 07-р сар

Энэ оны эхний 7 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 33.9%-иар буюу 1,482 сая ам.доллараар өсч 5,857 сая ам.долларт хүрсэн. Үүнд экспорт 39%-иар буюу 979 сая ам.доллараар, импорт 27.5%-иар буюу 504 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөлжээ. Тайлант хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 1,184 сая ам.доллараар давснаар гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 475 сая ам.доллараар өссөн байна


Гадаад худалдааны үзүүлэлтүүд (сая ам.доллар)



Томоохон экспортлогч орнууд



Экспортын зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн (сая ам.доллар)





М.НУРГУЛ: УЛС ЭХ ОРНОО САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ БҮХИЙ ИРГЭДТЭЙ, ӨНДӨР ХӨГЖИЛТЭЙ УЛС ОРОН БОЛГОХЫН ТӨЛӨӨ ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛЦГАА

Тэгвэл иргэдийн санхүүгийн мэдлэг сайжрах нь тухайн иргэнд болоод нийгэмд ямар ач холбогдолтой вэ? Төв банк үүнд оролцдог шалтгааныг тайлбарлана уу?

Төв банк боловсролын байгууллага биш учраас санхүүгийн мэдлэгийн талаар ярихаар яагаад гэж гайхах, эсвэл үндсэн ажлаа хийгээч гэж шүүмжлэх хүн цөөнгүй. Гэхдээ Төв банк эдийн засгийг тогтвортой байлгах гол зорилгоо амжилттай биелүүлэхийн тулд санхүүгийн боловсролд анхаарахаас өөр аргагүй болдог. Учир нь хүн бүр л мөнгө, санхүүтэй холбоотой шийдвэрийг өдөр тутам гаргаж, эдгээр шийдвэрүүдийн үр дүнд эдийн засаг маань бүрэлдэн тогтож байна. Тэгэхээр иргэдийн санхүүгийн мэдлэг сайжирснаар илүү оновчтой шийдвэр гаргах боломж нь нэмэгдэж, улмаар эдийн засаг маань тогтвортой байхад нөлөөлнө гэсэн үг. Түүнчлэн, Төв банкнаас хэрэгжүүлж буй бодлогыг илүү сайн ойлгох нь эргээд мөнгөний бодлогын хэрэгжилт, үр дүнтэй байдалд эерэгээр нөлөөлж буй. Иймд Төв банкууд санхүүгийн боловсролд анхаарч буй нь боловсролын байгууллагуудын урдуур орж ажлыг нь хийх гээд байгаа зүйл биш, харин мөнгөний бодлогынхоо нөлөөллийг дээшлүүлэхийн тулд хийж буй зүйл юм. Тийм ч учраас дэлхийд тэргүүлэх гол Төв банкууд бүгд санхүүгийн боловсролын хөтөлбөртэй байна.

Иргэдийнхээ санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд дэлхийн улс орнууд өндөр ач холбогдол өгдөг болсон гэж та сая хэллээ. Тэгвэл иргэдэд санхүүгийн мэдлэг олгох арга зүй, хөтөлбөр нь дэлхий нийтээр нэг стандартын дагуу хэрэгждэг үү эсвэл тухайн улс орны онцлогоос хамаарч өөр өөрөөр боловсруулагддаг уу?

2011 оны байдлаар 26 улс санхүүгийн боловсролыг дээшлүүлэх албан ёсны хөтөлбөр боловсруулан,

Бид өмнөх дугаартаа санхүүгийн боловсролыг олон улсад ямар хэмжээнд үнэлдэг, хэрхэн түгээдэг тухай дэлгэрэнгүй мэдээллийг хүргэсэн билээ. Тэгвэл энэ удаад дэлхийн улс орнууд санхүүгийн боловсролыг бодлогын түвшинд хэрхэн түгээдэг, Монгол Улс энэ чиглэлээр ямар стратеги баримтлаж байгаа талаар Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвийн ахлах мэргэжилтэн М.Нургултэй ярилцлаа.

Юуны өмнө санхүүгийн мэдлэг гэж яг юу вэ гэдэг асуултаас яриагаа эхэлцгээх үү?

Санхүүгийн мэдлэг гэдэг нь өргөн утгаараа мөнгөтэй холбоотой гаргаж буй аливаа шийдвэрээ аль болох оновчтой байлгах үүднээс тухайн хүн мэдээлэл цуглуулж, түүн дээрээ дүгнэлт хийх чадвар, арга барилыг хэлж буй. Орчин үед эдийн засагт санхүү, мөнгөтэй холбоотой маш олон бүтээгдэхүүн үйлчилгээ бий болсон байна. Зөвхөн банкны хадгаламж л гэхэд дотроо маш олон төрөл бий. Эдгээрээс алийг нь сонговол танд хамгийн ашигтай вэ гэдэг нь наад захын асуудал юм. Дээр нь инфляци, ханшийн нөлөө гэх мэт эдийн засагт өрнөж буй үйл явдлууд таны хадгаламжид хэрхэн нөлөөлөх вэ? Банкинд хадгалуулахгүй бол өөр ямар сонголт байна вэ? Тэдгээрийн эрсдэл нь юу вэ? Энэ бүх дүр зургийг томоор нь олж хараад, өөрт хамгийн оновчтой шийдвэр гаргах чадвар чухал юм. Тэгэхээр санхүүгийн зах зээл дээр байгаа бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх суурь ойлголтоос эхлээд, эдийн засгийн үзүүлэлтүүдийн харилцан уялдаа хүртэлх цогц мэдлэг, эдгээр дээр дүгнэлт хийх чадварыг санхүүгийн мэдлэг гэж ойлгож болно.

хэрэгжүүлэх шатандаа явж байсан бол 2016 оны байдлаар 60 улс олон нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, тусгайлан стратегитай болоод байна. Санхүүгийн боловсролын хөтөлбөрийг боловсруулахдаа улс орнууд дэлхийн хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлага төдийгүй өөрийн орны онцлог байдал, хүн амын санхүүгийн мэдлэгийн түвшинг харгалзан үзэж хөтөлбөрийнхөө чиглэл, зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг тодорхойлдог гэж ойлгож болно. Өөрийн улс орны онцлогт тохирсон агуулгатай хөтөлбөрүүд амжилтанд хүрч, харин тэгж чадаагүй бол үр дүн багатай байдаг.

Дэлхийн бусад улс орны иргэдтэй харьцуулахад Монголчуудын санхүүгийн боловсролын түвшин өнөөдөр ямар хэмжээнд байна вэ? Сайжруулахын тулд ямар бодлого хэрэгжүүлж, хэрхэн ажиллаж байна вэ?

Дэлхийн банкнаас 2012 онд Монгол Улсын санхүүгийн салбарт хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж буй байдал, иргэд олон нийтийн эдийн засаг, санхүүгийн боловсролыг олон улсын түвшинтэй харьцуулан судалгаа хийхэд харамсалтай нь хангалтгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Судалгаагаар манай улстай ижил түвшний орлоготой бусад орны иргэдийн адилаар Монголчуудын дийлэнх олонх нь хуримтлал болон хөрөнгө оруулалтын хамгийн үр өгөөжтэй шийдвэр гаргах, хууль ёсны эрхээ хамгаалуулахад шаардлагатай санхүүгийн үндсэн ойлголтын талаар хязгаарлагдмал мэдлэгтэй байгаа нь тодорхой харагдсан байдаг. Тиймээс иргэд, үйлчлүүлэгчдийн санхүүгийн шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэг, мэдээллийг хүргэдэг, эрх нь зохих хэмжээнд хамгаалагдсан байхыг баталгаажуулах нь чухал гэж үзсэн. Иймээс Монголбанк, Сангийн яам, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам, Санхүүгийн Зохицуулах Хороо хамтран Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлээд явж байна.

Хөтөлбөрийн хүрээнд ямар ажлууд хийгдэх, хэр удаан үргэлжлэх вэ?

Олон улсын туршлагаас үзэхэд хүний хандлага, дадал өөрчлөгдөхөд багагүй хугацаа шаардагддаг бөгөөд дунджаар 5 орчим жил байдаг гэж тооцдог. Иймд Санхүүгийн боловсролын хөтөлбөрийг дунд

хугацаагаар буюу 6 жилээр баталсан. Хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн “Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-т санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” нэртэй хичээлийг шинээр сургалтын хөтөлбөрт нь тусгасан. Түүнчлэн, их дээд сургуулиудад мэргэжил харгалзахгүйгээр үзэх “Хувь хүний санхүү” нэртэй 3 кредит хичээлийг боловсруулж сурах бичиг, дасгал ажлын ном нь бэлэн болсон байгаа. Дээр нь хөтөлбөр батлагдсанаас хойш ХААИС, СЭЗИС, Этүгэн, Улаанбаатар эрдэм, зэрэг сургуулиудад тус хичээлийг 2017-2018 оны хичээлийн жилийн сургалтын хөтөлбөрт нь оруулахаар болсон. Үүнээс гадна орон нутгийн иргэдэд зориулсан санхүүгийн мэдлэг олгох маш энгийн хялбар хэллэгтэй 13 төрлийн гарын авлагыг боловсруулаад байна. Сэдвүүд нь мөнгөө хэрхэн удирдах, төсөв болон санхүүгийн төлөвлөлт, хадгаламж, зээл, хөрөнгө оруулалт, даатгал, тэтгэвэр, нийгмийн даатгал болон татварын талаарх ойлголт, санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаарх ойлголт болон ханш г.м яг л иргэдэд санхүүгээ зөв удирдахад нь дэм болох агуулгаар боловсруулагдсан. Мөн энэхүү агуулгыг түгээх сургагч багш нарыг БСШУСЯ-ны харъяа “Насан Туршийн Боловсролын Үндэсний Төв”, “Бичил Санхүүгийн Хөгжлийн Сан”-тай хамтран бэлдсэн байгаа. Цахим орчинд www.sankhuuginbolovsrol.mn вэбсайт, ухаалаг утас ашигладаг хүн бүрийн ашиглах боломжтой “Төсөвчин” аппликейшнийг ч боловсруулж нийтийн хүртээл болгоод байна.

Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд юу чухал вэ?

Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгыг амжилттай биелүүлэхийн тулд мэдлэгийг системтэй түгээх нь хамгийн чухал бөгөөд үүнд төрийн бодлого гол үүрэг гүйцэтгэдэг. Иймд бодлого өөрөө тууштай хэрэгжих нь туйлын чухал. Үүнээс гадна бодлого тодорхойлогчид, боловсролын байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хувийн секторын хамтын ажиллагаа ч чухал. Тэгээд мэдээж иргэд өөрсдөө хэр хичээхээс маш их зүйл шалтгаална. Иймд тал бүрээсээ хамтдаа зүтгэж, улс эх орноо санхүүгийн боловсрол бүхий иргэдтэй, өндөр хөгжилтэй улс орон болгохын төлөө хувь нэмрээ оруулцаа гэж уриалмаар байна.



МОНГОЛЫН ЭСТРАД ХӨГЖМИЙН УРСГАЛЫН ТҮҮХЭНД ӨВӨРМӨЦ ӨНГӨ НЭМСЭН “ЭРДЭНЭС” ХАМТЛАГ

“Эрдэнэс” хамтлаг гэхээр 80, 90-ээд оны залуус андахгүй. Монголын эстрад хөгжмийн урсгалын түүхэнд өвөрмөц өнгө нэмсэн, дан бүсгүйчүүдээс бүрдсэн цахилгаан хөгжмийн энэ хамтлаг цаг үедээ жинхэнэ содон үзэгдэл, үзэгчдийн хувьд хүлээлт үүсгэсэн баг байв. Тухайн үеийн залуусын оргил он жилийн дурсамжаас “Эрдэнэс” хамтлагийн уран бүтээл одоо ч тодхон харагдана. Дууг нь сонсох гэж задгай талбай руу яарч, даган дуулж, дуунд нь бүжиглэж байсан тэр цаг үе, залуу насыг нь санагдуулдаг учраас тэд “Эрдэнэс”-ийг мартаж учиргүй.

Цаг үеийн залуусаа “байлдан дагуулж”, шинэ шинэ уран бүтээлээр сонорыг нь мялаан гялалзаж байсан тус хамтлаг төгрөгийн тогтвортой байдлыг хангах бодлогын уурхай болсон Төв банкны дэргэдэх хамтлаг байсан ээргээрээ онцлог. Хамтлагийн бүсгүйчүүд маань шинэ цомгоо гарган, залгамж халаагаа бэлтгэх нөр их ажлыг эхлүүлсэн тухай сайхан мэдээг цаг үеийн залуучуудад

нь хүргэж байгаадаа баяртай байна.

“Эрдэнэс” хамтлаг 1984 онд одоогийн Монголбанкныг хуучнаар Улсын Банк нэртэй байхад нь Улсын Банкны Ерөнхий Хорооны дэргэд байгуулагдаж байсан түүхтэй. Албан байгууллагуудын дунд урлаг спортын уралдаан тэмцээн тогтмол зохион байгуулагдаж, олон нийтийг соён гэгээрүүлэхэд анхаарч байсан тэр цаг үед тухайн нийгэм өөрөө “Эрдэнэс” хамтлагийг төрүүлсэн байв.

Хамтлагийн нэрийг УБЕХ-ны даргаар тухайн үед ажиллаж байсан Л.Хүдэрчулуун, дэд дарга н.Янсан нар хамт олонтойгоо хэлэлцэж байгаад оноож өгчээ. Утга агуулга талаас нь сайтар тунгаавал “Эрдэнэс” гэх нэр нь Монгол Улсын мөнгөн тэмдэгт, алт, мөнгө, эрдэнэсийн санг илэрхийлнэ. Хамтлагийн нэрний утга ийм дурсамжийг илэрхийлдэг.

Ийнхүү хорооныхоо хамгийн авъяаслаг таван бүсгүйг сонгосон дарга нар, тэднийг сампин цохиж, тооны машинд тоо хийж суухын хажуугаар дуулж



"Эрдэнэс" хамтлагийн анхны бүрэлдэхүүн
Эстрад дуу дуулаачдын уралдаан 1984 он

хөгжимдөх нөхцөл боломжийг нээж өгсөн нь энэ. Тэд "Бүүвэйн дуу", "Хаврын өглөө", "Энхтайван" зэрэг дуугаар урын сангаа нээж, Бүх ард түмний их наадмаас алт, мөнгөн медаль, Ая дууны жигүүр, Рок попын анхдугаар уралдаануудаас тэргүүн болон удаах байрын шагналыг хүртэж эхэлсэн юм.

Урлагийн тайзан дээр мэргэжлийн уран бүтээлчидтэй эн зэрэгцэх болсон "Эрдэнэс" хамтлагийнхан энэ цагаас эхлэн урилга заллагад дарагдан, баярын болон хүндэтгэлийн концертуудад оролцож, цэнхэр дэлгэцнээ үзэгчдийн хүсэн хүлээдэг байсан "Ая дууны мэндчилгээ" болон бусад дуу хөгжмийн нэвтрүүлгүүдэд уригдан, хот хөдөөгүй бүрэн хэмжээний тоглолтоо хийж, өөрийн гэсэн хүсэн хүлээдэг үзэгчидтэй ч болж алдаршсан байдаг.

Түүнчлэн ОХУ (хуучнаар Зөвлөлт Холбоот Улс)-ын хээрийн банкныханд зориулан тоглолт хийж явсан байдаг. Мэргэжлийн эстрадын уран бүтээлчидтэй эн зэрэгцсэн "Хос морьтой" "Эрдэнэс" хамтлаг тухайн үед Монголын радиогийн алтан фондод найман дуу бичүүлж хадгалуулсан нь одоо ч радио долгионоор эгшиглэж байна. Эстрад урлагийн 80-90 оны түүхийг бүтээлцсэн уран бүтээлчдийн урын сан өнөөдөр ч дундраагүй явна. Тэд Монголбанкнаа дуу хөгжмөө эгшиглүүлсээр яваа. Ингээд тун удахгүй уран бүтээлийнхээ цомгийг үзэгч олноо өргөн барих гэж байгаа хамтлагийн бүсгүйчүүдийн ярианд Таны анхаарлыг хандуулъя.

Хамтлагийн ахлагч Ч.Мөнхзул /Монголбанкны Мөнгөн тэмдэгтийн газрын ахлах хянан шалгагч/

Манай хамтлаг үзэгч сонсогчид, эстрад урлагийн үе тэнгийн уран бүтээлчдийнхээ тайлан тоглолтоо хийгээч гэсэн хүсэлтэд зориглон энэ ажлыг эхлүүлсэн. Өнөөдөр бид хэдий эстрад урлагт өөрийн гэсэн онцгой байр суурьтай хэдий ч урлаг гэдэг нь уран бүтээл хийж байж хөгждөг жамаар бид уран бүтээлээ туурвисаар байна.

Өнгөрсөн 33 жилийн хугацаанд бид урын сандаа бүрэн хэмжээний 3 цагийн тоглолтын дуу хөгжимтэй болсон ч цаг үетэйгээ уялдаж шинээр уран бүтээл туурвисаар ирсэн. Одоо гаргаж байгаа цомог маань олон түмэнд хэдийнээ танил болсон уран бүтээлээс гадна шинээр хийгдсэн уран бүтээлээсээ ч түүвэрлэн шилдэг 12 дууг багтаасан байгаа. Цомогны нүүрэнд Төв банкныхаа лого, алт эрдэнэсийн шар өнгө, алтан зоосыг оруулж өгсөн ба "Эрдэнэс" хамтлаг нь банкаар овоглосон Монголбанкны хамтлаг юм. Хэдий бид мэргэжлийн түвшний уран бүтээлчид биш хэдий ч тухайн нийгмийн шаардлагаар хамтлаг маань байгуулагдаж, өнөөдрийг хүртэл анхны "Эмэгтэйчүүдийн цахилгаан хөгжмийн хамтлаг" гэсэн эрхэм хүндтэй нэр хүндийг хадгалж яваадаа баяртайгаас гадна бахархаж явдаг.

Хамтлагийн сүүлийн бүрэлдэхүүн өнөөдрийг хүртэл уран бүтээлээ туурвиж байгаагийн дээр Монголбанкны Мөнгөн тэмдэгтийн газар Ч.Мөнхзул, К.Янжиддулам нар ажиллаж байна. Тухайн үед хамтлагийн гишүүд Улаанбаатар хотын банкны ажилтнууд байсан бол өнөөдөр Б.Туяа Швейцар Улсад амьдардаг, Д.Дэчинмаа жүдо бөхийн тамирчин, Э. Оюунбилэг хувиараа хөдөлмөр эрхэлдэг, дуучин Оюунгэрэл БНСУ-д ажиллаж, амьдарч байна.

Хамтлагийн гишүүд маань үе тэнгийн, дээр нь банкны хариуцлагатай ажлыг хийдэг байсан учраас өнөөдрийг хүртэл биднийг нэгтгэж, хариуцлагатай байх зарчмаар хүмүүжүүлжээ. Тухайн үед уран бүтээл туурвихад яг л цуглах цагтаа цуглаж, хийх ёстой уран бүтээлээ туурвиж чаддаг байжээ. Бид хөгжмөө өөрсдөө зөөж, залгаж, хөглөж, тоглож дээр нь өөрсдөө уран бүтээлээ туурвиж байсан байна. Тэгэхээс ч өөр аргагүй байжээ.

Тухайн нийгмийн шаардлагаар олон ажилтануудтай байгууллагууд соёл, урлагийн арга хэмжээгээ зохион байгуулах зорилгоор байгууллагын дэргэдэх хамтлагийг байгуулж, орон тооны хамтлаг ажиллаж байсан. Бидний хувьд өдөр нь ажлаа хийж, ажлын дараа бэлтгэлээ хийж баяр ёслол үдэшлэгт хөгжимөө тоглож уран бүтээлээ туурвиж байжээ.

1991 оноос 2 шатлалт банк үүсч манай хамтлаг хөгжимгүй болж зарим гишүүд маань арилжааны банк руу шилжсэнээр бид тус тусын амьдралаа хөөж уран бүтээлээсээ хөндийрсөн ч энэ завсар хамтдаа дуугаа дуулж, амьд хөгжим дээр тоглох хүсэл маш их байсан. Ингээд анх 1999 онд хамтлагаараа нийлж шинээр дуугаа бичүүлж түүнийгээ дүрсжүүлж 2005, 2007 онуудад Монголбанкныхаа шинэ жилийн арга хэмжээнд ая дуугаа өргөж ТВ9 телевизийн “Ретро аккорд” нэвтрүүлэгт оролцож байсан.

CD гаргах болсон тухайд гэвэл эстрад урлагийнхан маань та нар анхны цахилгаан хөгжмийн эмэгтэй хамтлаг. Өнөөдрийг хүртэл ийм хамтлаг байхгүй байна. Эрдэнэсийн гишүүд бүгд байгаа болохоор ямар нэгэн тоглолт эсвэл тайлан тоглолт хийгээч гэдэг санал тавьдаг. Ингээд бид дуулж байсан дуунуудаасаа түүвэрлээд, бөмбөрчин Р.Дэчинмаагийнхаа зохиосон 2 дууг нэмээд дуулж нийт 12 дуугаар CD-гээ гаргаж байгаадаа баяртай байна. Урлагийн амьдралаас хол хөндий явсан болохоор нилээд бэрхшээлтэй байсан хэдий ч хэсэг хугацааны дараа хэвэндээ орж CD-ний ажил маань амжилттай дуусаж байна. Бид банкаар овоглосон Монголбанкны “Эрдэнэс” хамтлаг. Үе үеийн банкны ажилтнууд, удирдлагууд маань дэмжиж тусалдаг болохоор өнөөдрийг хүртэл 33 жил бид оршиж байна. Өнөөдрийн биднийг дэмжиж байгаа хамт олон, удирдлагууд, бидний дууг сонсогч фенүүд та нарын дэмжлэг туслалцаатайгаар CD маань гарсан болохоор энэ бидний хамтын бүтээл юм аа. Та нартаа маш их баярлалаа. Мөн биднийг дэмжиж тусалж байгаа гэр бүлийнхэндээ баярлалаа.

Басс гитарчин К.Янжиддулам: Өнөөдөр бид тус тусын амьдралаа хөөж холдсон хэдий ч шаардлагатай үед цуглаж аливаа арга хэмжээнд оролцож явжээ. 1999 онд Монголбанкны шинэ жилийн арга хэмжээнд ая дуугаа өргөж түүнээс хойш банкны ажилчиддаа бүрэн бүрэлдэхүүнээрээ 2 ч удаа ая дуугаа өргөж, дараа нь



Улаанбаатар хотын банкны Улаан булан 1999 он.

Ч.Мөнхзул бид 2 мөн нийлж ая дуугаа өргөж байлаа. Бид хэдий сампинчид хэдий ч хөгжимдөө дуртай нот мэдэхгүй ч сонсголоороо дууныхаа барилтыг цээжилчихдэг. Одоо хөгжимөө нийлж тоглоход гар аяндаа л тоглох нотоо тоглож байна. Хамтлагаараа нийлээд гитараа бариад дуугаа дуулахад сайхан байна.

Соль гитарчин Б.Туяа: Хамтлагийнхаа гишүүдийн санаачилсан CD-ний ажилд оролцож байгаадаа баярлаж байна. Хэдий би Швейцарт амьдарч байгаа ч сэтгэл зүрхээрээ хамтлагийнхантайгаа үргэлж хамт байдаг. Уран бүтээлийнхээ ажилд хамтран оролцоход хуучны дурсамж сэргээд сэтгэл их хөдөлж сайхан байна. Зураг авалтаар Монгол эх орныхоо байгалын сайхныг биширч явлаа. Үнэхээр л сайхан орон юм шүү дээ.

Даралтат хөгжимчин Э.Оюунбилэг: Бид их том ажлын ард гарлаа. Хамтлаг бол багаар ажилладаг, гарсан бүтээл нь ч хамтын бүтээл байдаг. Энэ утгаараа санаа бодол нийлж, сайхан уран бүтээл туурвиж бүтээж чадсан та нартаа баярлалаа.

Бөмбөрчин Р.Дэчинмаа: Дууны инженер П.Сүхбаатар ах маань бидэнтэй уйгагүй ажиллаж хөгжим, дууны үг ер нь ажиллах бүх л талаар бидэнд тусалсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

Аливаа улс орны өмнө тулгардаг нэн чухал зорилт нь эдийн засгийн тогтвортой, хүртээмжтэй өсөлт юм.

Эдийн засгийн өсөлт:

Эдийн засгийн өсөлт нь тухайн улс орны хэмжээнд үйлдвэрлэсэн нийт бараа үйлчилгээний хэмжээ өмнөх оноос хэр их нэмэгдсэн бэ гэдгийг харуулдаг үзүүлэлт юм. Үүнийг ДНБ-ний өсөлт ч гэж нэрлэдэг.

Ард түмний амьдралыг дээшлүүлэхийн тулд эдийн засгийн өсөлт нь урт хугацаанд тогтвортой бөгөөд хүртээмжтэй байх ёстой.




Тогтвортой, хүртээмжтэй өсөлтөнд нөлөөлөх хүчин зүйлс:

1. Институци=Хууль, Засаглал
2. Бодлого=Мөнгөний бодлого, Сангийн бодлого
3. Хүн=Хүн ам, Боловсрол

Монгол Улсын эдийн засгийн өсөлт

/Үйлдвэрлэлийн аргаар тооцсон/




Эх сурвалж: Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо

Эдийн засгийн мөчлөг гэж юу вэ?

Аливаа улс орны эдийн засаг нь өсөлт, уналт ээлжилдэг мөчлөгтэй байдаг. Энэхүү мөчлөгийн хэлбэлзлийг аль болох бууруулах нь бодлого тодорхойлогчдын зорьдог зүйл юм.

Эдийн засгийн мөчлөг





Б.ТУЛГА: ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ, ТОГТВОРТОЙ БОДЛОГООС ЭХЭЛНЭ

Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банкны Гүйцэтгэх захирал Б.Тулгатай ярилцлаа.

■ **Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк байгуулагдаад 11 дэх жилдээ ажиллаж байгаа юм байна. Анх байгуулагдсанаасаа хойших өнөөг хүртэлх хөгжлийн замналаа товчхон дурдвал ямар вэ? Энэ талаар ярилцлагаа эхэлье?**

-Манай банкны хувьд 2006 онд нээгдсэн цагаасаа хойш жил

бүр тогтвортой өсч, харилцагчид болон үйл ажиллагааныхаа цар хүрээг нэмэгдүүлж ирсэн. Банк бий болох, өнөөдрийн түвшинд хүрэхэд маш олон хүний хөдөлмөр, ур ухаан, сэтгэл шингэсэн. Хамгийн чухал нь бидэнд итгэж биднээр үйлчлүүлж ирсэн манай харилцагчид юм. Өнөөдөр 13 салбар, нэгжээр үйл ажиллагаа

явуулж эдийн засагт өөрийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна. "Global Banking and Finance Review" олон улсын байгууллагаас "Монгол Улсын хурдацтай хөгжиж буй харилцагчийн үйлчилгээтэй банк", "Монгол Улсын хурдацтай хөгжиж буй байгууллагын банк"-аар тус тус шалгарч байсан. Цаашдаа ч банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг шинэ



түвшинд гаргахаар сэтгэл нэгдэн ажиллаж байна.

■ Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк гэхээр бизнесийнхэн л голдуу харилцдаг болов уу гэж бодож байна. Иргэд, харилцагчдын хувьд танай банкны талаар мэдээлэл багатай юм шиг санагддаг. Танай банкны үйл ажиллагааны гол онцлог, давуу тал, зорилт юу вэ?

-Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банкны тухай дээрх ойлголт байдаг нь эхний жилүүдэд ихэвчлэн байгууллагын банкны үйл ажиллагаанд төвлөрч байсантай холбоотой. Өнөөдөр манай банкны хувьд иргэд болон аж ахуйн нэгж бүхий л харилцагчдад нээлттэй. Бусад бүх арилжааны банкин дээр байдаг зээл, хадгаламж, карт, пос, интернет банк, мобайл банк, гадаад гүйлгээ, баталгаа батлан даалт, гадаад худалдааны санхүүжилт

гээд бүх үйлчилгээг хүргэж байна. Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, Өмнөговь аймагт байгаа салбаруудаар харилцагч ирээд дараалал багатай үйлчлүүлж болж байна. Банкны системд хэтэрхий олон банк байна, одоо өөр зах зээл байхгүй гэж олон хүн боддог. Гэхдээ бид банкууд хоорондоо өрсөлдөхөөс гадна дотоод зардлаа бууруулах, технологи нэвтрүүлэх, харилцагчдынхаа зардлыг хэмнэх тал дээр маш их боломж байна гэж харж байгаа. Бид харилцагчдаа аль болох цаг хугацаа хэмнэж интернэт банк, мобайл банк ашиглаасай гэж зөвлөдөг. Бид банкныхаа үнэт зүйлсэд бүтээлч байгууллага, шинэ технологи, үр ашигт гүйцэтгэл гэж тусган ажиллаж байна.

■ Танай банкны зорилго, зорилтыг үндэсний үйлдвэрлэлийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар дэмжих

гэж ойлгож байгаа. Монгол Улс эдийн засгийн хувьд амаргүй жилүүдийг үдэж байна. Эдийн засгийн хүндрэл, бэрхшээлтэй үед Үндэсний Хөрөнгө Оруулалтын Банк хэрхэн ажиллаж ирсэн бэ?

-Манай банкны хувьд байгууллагын төслийн санхүүжилт чиглэлээр төвлөрч ажиллаж ирсэн. Үүсгэн байгуулагдсан цагаас хойш өнөөг хүртэл цөөнгүй төслүүдийг өөрийн санхүүжилтээр санхүүжүүлэхээс гадна ХХААХҮЯ, ЖДҮХСан, Хөгжлийн банк, Монголбанк, Азийн Хөгжлийн Банкны олон төслүүдэд оролцож, дамжуулан зээлдүүлэх замаар үйлдвэрлэгчдээ дэмжиж иржээ. Зээлдэгч, харилцагч нарын хувьд эдийн засгийн хямрал маш хүндээр тусч байна. Энэ бүхэн эргээд зээл төлөлт, санхүүгийн гүйлгээнд сөргөөр нөлөөлдөг. Банкны зүгээс энэ үед харилцагчидтайгаа илүү ойр хамтран ажиллах, хамтарсан хөтөлбөрүүд гаргаж борлуулалтыг дэмжих зэрэг олон талт үйл ажиллагаа явуулж байна.

■ Та үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих зорилготой банкиг удирдаж байгаа хүн. Тийм учраас Монголд үйлдвэрлэлийг хөгжүүлэх гарц, боломжийн талаар өөрийн гэсэн үзэл бодолтой байх. Монголд үйлдвэрлэлийг хөгжүүлэх ямар боломж, гарц байна вэ? Үүнд банкны системийн гүйцэтгэх үүрэг ч бас их чухал байх. Энэ талаар?

-Үндэсний үйлдвэрлэл гэхээр ихэнхи хүмүүст эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл төсөөлөгддөг. Бид бүх зүйлийг



**Хамгийн
эхэнд экспортын
бүтээгдэхүүнүүдээсээ
эхлэх боломж байна.
Боловсруулж нэмүү
өртөг шингээхгүй
байгаа түүхий эд,
эрдэс, баяжмал,
нөөцийнхөө
анхан шатны
боловсруулалтыг
хийдэг үйлдвэрүүд нэн
тэргүүнд шаардлагатай
байгаа. Үүн дээр
бидэнд өрсөлдөгч
байхгүй гэсэн үг.**

өрсөлдөхүйц нөхцөлтэйгээр үйлдвэрлэж чадахгүй. Ихэнх бүтээгдэхүүнийг хүссэн хүсээгүй гаднаас авах хэрэгтэй. Монголд үйлдвэрлэлийг хөгжүүлэх гарц, боломж гэвэл үндэсний стратеги, хөгжлийн тогтвортой бодлогуудаас эхэлнэ гэж боддог. Бид юуг давуу нөхцөлтэйгээр үйлдвэрлэх боломжтой вэ? Ямар давуу тал байгаа вэ? гэдгээ бодолцох хэрэгтэй. Түүнээс биш голлох чиглэлүүдээ удаж төдөлгүй өөрчлөөд ашиггүй төсөлд эдийн засгийн нөөцөө урсгаад байж болохгүй. Хамгийн эхэнд экспортын бүтээгдэхүүнүүдээсээ эхлэх боломж байна. Боловсруулж нэмүү өртөг шингээхгүй байгаа түүхий эд, эрдэс, баяжмал, нөөцийнхөө анхан шатны боловсруулалтыг хийдэг үйлдвэрүүд нэн тэргүүнд шаардлагатай байгаа.

Үүн дээр бидэнд өрсөлдөгч байхгүй гэсэн үг. Банкны системийн үндсэн үүрэг энэ үйлдвэрлэлүүдийг бий болгох санхүүжилтийг дамжуулах, эрсдэлийг хуваалцах, дэмжихээс эхэлнэ.

■ Монголын банкны системийн өнөөгийн нөхцөл, байдлын талаар таны бодлыг сонсьё. Мөн цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар та ямар бодолтой байдаг вэ?

-Банкны систем туулах ёстой үе шатуудаа зах зээлийн хуулийн дагуу туулаад явж байгаа гэж хардаг. Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, хүртээмжээр ихэнх улстай харьцуулах юм бол манай систем нэлээн дээгүүр жагсана. Зээлийн хүү, хадгаламжийн хүү, бодлогын хүү аль аль нь өндөр байна. Гэхдээ үүнээс ч өндөр үе байсан. Одоо тогтвортойгоор буурч байна. Иргэд хуримтлалын талаар ойлголттой болж байна, хуримтлал хийж байна. Компаниудын сахилга бат харьцангуй сайжирч байна. Нэг талаас банкны систем гэж харж болох ч нөгөө талаас энэ системийг иргэд, аж ахуйн нэгжийн санхүүгийн боловсрол, санхүүгийн зохистой хэрэглээ, санхүүгийн соёлын толь гэж харж болно. Санхүүгийн боловсрол, хэрэглээ, соёл нэвтрэхийн хэрээр үйлчилгээний чанар олон улсын гэж яригдаж байгаа түвшин лүүгээ дөхнө. Зөвхөн зээл, хадгаламжаар банкиг төсөөлдөг байсан төсөөлөл өөрчлөгдөнө. Гэхдээ энэ өөрчлөлт өмнөх жилүүдийн өөрчлөлтөөс илүү хурдацтайгаар явагдах болов уу.

■ Бас нэг зүйлийг асуухад Монголбанкнаас "Монгол Алт" аяныг эхлүүлээд байгаа. Та эдийн засагч хүний хувьд иргэд, аж ахуйн нэгжүүд олборлосон алтаа Монголдоо, Монголбанкинд тушаахын ач холбогдол, давуу талыг манай уншигчдад тайлбарлах уу?

-Монголбанкнаас хэрэгжүүлж буй "Монгол Алт" аяны эдийн засгийн ач холбогдлыг өндрөөр харж байгаа. Дэлхийн зах зээлийн үнээр иргэд, ААН-үүдэд хүндрэл багатай, нээлттэй мэдээлэлтэйгээр алт худалдан авч эхэлснээр алтны арилжаа тодорхой хэмжээнд ил гарч ирэх, улсын төсөвт орж ирэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нэмэгдэх, алтны нөөц нэмэгдэх, цаашлаад валютын ханш тогтворжих зэрэг олон сайн үр дүн гарах болов уу. "Алт 2" хөтөлбөрийн хувьд банкууд алтны компаниудыг санхүүжүүлэхдээ ToC хөтөлбөрийн хүрээнд нөхөн сэргээлтийн асуудлаа бүрэн шийддэг, тухайн орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулдаг сайн компаниудыг дэмжээсэй гэж уриалж байна.

-Ярилцсанд баярлалаа.

АЗИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТ, ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУД



Б.Түмэнцэнгэл
(Монголбанкны ОНБМТ-ийн
Ахлах эдийн засагч)

2017.09.07-ноос 09-ний өдрүүдэд БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулагдсан “Азийн эдийн засгийн тогтвортой өсөлтийн хэтийн төлөв ба тулгарч буй сорилтууд” сэдэвт олон улсын конференцийн үеэр яригдсан гол зүйлсийг тоймлон хүргэж байна. Тус хурлын үеэр Азийн гол Төв банкуудын төлөөллүүд, ОУВС, Питерсон институти зэрэг байгууллагуудын экспертүүд бүс нутгийн бодлого тодорхойлогч нарт тулгарч буй асуудлуудын талаар хийсэн судалгаагаа танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

Азийн талаар

Ази тивд өнөөдөр 4.4 тэрбум хүн буюу дэлхийн хүн амын 60 орчим хувь нь амьдарч байна. Хятад, Энэтхэг гээд тэрбум давсан хүнтэй их гүрнүүдээс гадна Япон, Солонгос, Сингапур зэрэг технологийн өндөр хөгжилтэй орнууд, цаашид өндөр потенциалтай гэгдэж буй Малайз, Индонези, Вьетнам, Камбож зэрэг улс орнууд тус бүс нутгийн өнөөгийн дүр төрхийг тодорхойлж буй.

Сүүлийн жилүүдэд Азийн улс орнууд дэлхийн эдийн засгийн 40%, харин бий болж буй ДНБ-ний өсөлтийн 2/3 %-ыг дангаараа бүтээдэг болсон. Тийм ч учраас Дэлхийн хөгжлийн “хүндийн төв” нь Баруунаас Зүүн рүү шилжиж байна гэж яригдаж байна. Үнэхээр ч дэлхийн эдийн засаг цаашид яах вэ гэдэг нь эдийн

засгийн өсөлтийнх нь гол “мотор” болж буй Азийн улс орнуудад байдал ямар байхаас шууд шалтгаалах юм.

Ази тив ийнхүү дэлхийн газрын зурган дээр чухал бүс нутаг болон тодорч гарч ирэхэд Япон, Солонгосын өндөр өсөлтийн үе, залгаад Хятад, сүүлийн үед Энэтхэг болон зарим Зүүн өмнөд Азийн орнуудад бий болсон эдийн засгийн эрчимтэй өсөлт гол түүчээ нь болсоор ирлээ. Үр дүнд нь зөвхөн Хятадад л гэхэд сүүлийн 30 жилд 800 сая хүн ядуурлаас гарчээ.

Мэдээж эдийн засгийн өсөлтийн зам үргэлж шулуун бөгөөд дардан байгаагүй юм. Тайландад эхэлж, Индонези, Солонгост үргэлжилсэн 1997 оны Азийн хямрал тус бүс нутгийн улс орнуудад том уналтыг авчирсан. Гэхдээ ханш савлаж, банкууд дампуурч, олон хүнийг ажилгүй болгосон тус хямралаас үлдсэн сургамж нь Азийн орнуудад 2008 оны дэлхийн санхүүгийн их хямралын үеэр харьцангуй бага хохирол амсах суурь нь болсон гэхэд болно.

Харин одоо Азийн орнуудын өмнө дэлхийн санхүүгийн их хямралаас хойшиг удаашралтай байдлаас хэрхэн гарах, цаашид тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг хэрхэн бий болгох, хүн ам зүйтэй холбоотой эдийн засгийн асуудлаа хэрхэн шийдэх вэ гэдэг сорилтууд тулгарч байна. Түүнчлэн, олон зуун сая

хүний амьдралын түвшин, хэрэглээ огцом нэмэгдсэнтэй холбоотой эрчим хүч, байгаль орчны тогтвортой байдлын асуудлууд ч чухал сэдэв болж байна.

Азид тулгарч буй сорилт: Богино хугацаанд

2008 оны их хямралаас хойш хөгжсөн болон хөгжиж буй орнуудын эдийн засгийн гүйцэтгэл олон жилийн дундаж хэмжээнээсээ нэлээд доогуур түвшинд хадгалагдаж буй. Энэхүү зүй тогтол Азийн орнуудыг ч тойрсонгүй. Өсөлт, инфляци, тэнцвэрт хүү түүхэн нам дор түвшинд хадгалагдаж, олон оронд эдийн засаг потенциал түвшнээсээ доогуур гүйцэтгэлтэй явсаар ирэв. Иймд бодлого тодорхойлогчдоод эдийн засгаа яаж энэхүү удаашралтай байдлаас гаргаж, цаашид хэрхэн тогтвортой бөгөөд хүртээмжтэй өсөлтийг бий болгох вэ гэдэг асуудал тулгарч байна.

Хүндрэлийн үед Азийн олон оронд эдийн засгийн идэвхжлийг дэмжихийн тулд тэлэх бодлогыг их хэмжээний зээлээр санхүүжүүлсэн нь нэг талаар хувийн секторын санхүүгийн байдлыг эмзэг болгож, харин засгийн газрын хувьд төсвийн орон зайг хумиад байгаа нь богино хугацааны сорилт болж байна. Энэ нь ялангуяа засгийн газрын өр ДНБ-ийн 220% давсан Япон, хувийн секторын өр хурдтай нэмэгдэж ДНБ-ний 170%-д хүрээд буй Хятад зэрэг томоохон эдийн засгуудад хамаатай юм.

Харин мөнгөний бодлогын хувьд хэт зөөлөн бодлого үргэлжилж буй ч, инфляцийн зорилтот түвшиндээ хүрэхгүй улс орнууд олон байна. Хүүний түвшин аль хэдийн хэт нам дор түвшинд орж Япон гэхэд аль хэдийн хасах хүүний бодлого руу шилжиж, Солонгост уламжлалт мөнгөний бодлогын арга хэрэгслийн нөлөө хязгаарлагдмал болов. Иймд дэлхийн эдийн засагт дахин нэг шок ирэх үед эдгээр Төв банкуудад ямар бодлогын орон зай үлдэж байна вэ гэдэг нь сорилт болж байна. Түүнчлэн, санхүүгийн тогтвортой байдлыг хангах макро зохистой бодлогуудыг хэрхэн хэрэгжүүлэх вэ гэдэг дээр чухал анхаарал тавигдаж буй.

Үүнийн зэрэгцээ, Азийн эдийн засгийн цөм болсон Хятадад өрнөж буй эдийн засгийг дахин тэнцвэржүүлэх өөрчлөлт нь урьдчилан тооцоолоогүй савлагаа, өөрчлөлтүүдийг бий болгох эрсдэлтэй. Мөн зарим улс орны улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалж олон улсад протекционист бодлого хүчээ авч буй нь

экспортод суурилсан Азийн олон эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Дунд болон урт хугацаанд

Азийн гол эдийн засгуудын хэтийн төлөвийг авч үзвэл ихэнхэд нь хүн амын насжилтын асуудал хурцаар тавигдаж, цаашдын эдийн засгийн чадавхид сөрөг нөлөө үзүүлэхээр хүлээгдэж байна. Японы хувьд гэхэд хүн амын 1/4 нь аль хэдийн 65-аас дээш настай болсон. Харин Солонгос болохоор Европ, Америкт үзэгдээгүй хурдаар хүн ам нь хөгширч буй. Хүн амын насжилт 2020-2050 оны хооронд Азийн хөгжсөн орнуудад эдийн засгийн өсөлтийг жил тутам 1 нэгж хувиар бууруулах нөлөөтэйг ОУВС-аас тооцоод буй.

Насжилт ийнхүү хурдтай өрнөж байгаа нь зөвхөн өндөр орлоготой улс орнуудын асуудал биш юм. Хятадад ч 1 хүүхдийн бодлогоос улбаатай төстэй зүй тогтол ажиглагдаж байна. Тайланд, Индонези, Энэтхэг зэрэг бусад хөгжиж буй орнуудын хувьд ч “Баяжихаасаа өмнө хөгшрөх” (getting old before becoming rich) үйл явц өрнөж буй. Цаашид төрөлт буурснаар залуу, үр бүтээлтэй ажиллах хүчний тоо багасч, харин тэтгэвэр тэтгэмж, халамжин дээр тогтдог ахмад настнууд өсч байгаа нь эдийн засгийг туйлдуулах гол хүчин зүйл болж байна.

Иймд ажиллах хүчний бүтээмжийг хэрхэн сайжруулах вэ, тэтгэврийн насыг уртасган ажиллах чадвартай ахмад настнуудын хувь нэмрийг эдийн засагт хэрхэн оруулах вэ, мөн ажиллах хүчинд эмэгтэйчүүдийн оролцоог хэрхэн нэмэгдүүлэх вэ, тэдний хөдөлмөр эрхлэх орчныг яаж сайжруулах вэ гэдэг нь Азийн орнуудын эдийн засгийг урт хугацаанд тогтвортой байлгах чухал хүчин зүйлс юм. Энэ бүхнийг амжилттай хэрэгжүүлэхэд олон улсын хамтын ажиллагаа чухал бөгөөд, “Азийн орнуудын туршлагаас бид маш их зүйлийг сурсан. Цаашид ч хамтран ажиллах, цуг суралцах замаар тус бүс нутгийн хүмүүсийн амьдралыг сайжруулах боломжтой” гэдгийг ОУВС-гийн тэргүүн Кристин Лагард онцолж байлаа.

Энэхүү нийтлэлд дурдах аливаа дүгнэлт, дэвшүүлсэн санал нь зөвхөн нийтлэлчийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Монголбанкны байр суурийг илэрхийлэх албагүй.



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

Бодлогын хүүг хэвээр хадгалах тухай

Мөрдөх огноо: 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр

Монголбанкны Мөнгөний Бодлогын Зөвлөл 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хуралдаж, Бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа.


Хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн жилийн инфляци 2017 оны 08 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 5.0 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 5.4 хувьд хүрлээ. Оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт хүлээлтээс давж, өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар өсөв. Цаашид эдийн засгийн өсөлт нэмэгдэж, инфляци дунд хугацаанд зорилтот 8 хувийн орчимд тогтворжих төлөвтэй байна.

Гадаад эдийн засгийн орчинд эерэг өөрчлөлтүүд гарч, экспортын бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдан, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа нь эдийн засгийг идэвхжүүлж байна. Зах зээлд оролцогчдын итгэл сэргэж, эдийн засагт ийнхүү нааштай хандлага гарч байгаа ч цаашдын төлөв нь экспортын үнэ, хэмжээнээс ихээхэн хамаарахаар байна.

Мөнгөний бодлогын төлөвийг хэвээр хадгалах шийдвэр нь инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах, улмаар макро эдийн засгийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилттой нийцэж байгаа болно.

Зөвлөлийн хурлын хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ



АЧИГЧИЙН БУРУУГААС ГААРДАГ ИНФЛЯЦИЙГ АРГАЛАХ АРГА, ЧАРГА НЬ ЮУ ВЭ?

Монголбанкнаас сэтгүүлчид дунд "ҮНИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ" сэдвийн хүрээнд зарласан "Шилдэг нийтлэл"-ийн уралдааны дэд байрын бүтээлийг танилцуулж байна.

Дэд байр: "Ub.Life" сайтын сэтгүүлч Э.ХУЛАН

"Инфляци ирэх оны эцэст 8 хувьд хүрэхгүй бол намайг юу ч хийгээгүйд тооцоорой" гэж Монголбанкны ерөнхийлөгч асан Н.Золжаргал таван жилийн өмнө тун зоримог мэдэгдэл хэвлэлээр дайж байв(www.olloo.mn, 2012.10.11). Тухайн үед инфляцийн хэмжээ 14 хувьтай тэнцэж байсан учраас ажил, албан тушаалаа аваад удаагүй Н.Золжаргал ерөнхийлөгчийн хүчтэй мэдэгдэл олныг алмайруулж орхисон юм. Яаж гэсэн асуулттай зэрэгцээд "Үнэ тогтворжуулах хөтөлбөр" гэх нэр дуулдаж эхэлсэн ба өдгөө Та бид энэ хөтөлбөрийн тухай мэдээлэлтэй болж амжжээ.

Монголбанк Үнэ тогтворжуулах хөтөлбөр нэрийн дор их наядаар хэмжигдэх төгрөг хэвлэж, мөнгөний нийлүүлэлтээ эрс нэмэгдүүлсний үр дүнд богино хугацаанд ДНБ-ийг идэвхжүүлж, 2013 онд хоёр оронтой тоогоор эдийн засаг өсөж, өмнөх жилүүдийн рекордоо хадгалсан юм. Харин үр уршиг нь үүнээс хэд дахин томорч, Монголын эдийн засгийг сөхрүүлэхэд чамгүй нөлөө үзүүлснийг шүүмжлэх эдийн засагчдын хоолой өнгөрсөн жилүүдэд чангарах тийшээ ханджээ. Эцэст нь, олон улсын банк санхүүгийн байгууллагууд "Монгол Улс төсвийн нэг бодлоготой явах учиртай" гэж удаа дараа зөвлөсний дагуу Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг зогсоосныг уншигч Та санаж байгаа байх. Үүгээр ч зогсохгүй өдгөө Монголбанкны 2012-2016 оны үйл ажиллагаанд шалгалт хийж байгаа юм.

Гэхдээ Монголын Төв банк л дангаар уламжлалт бус бодлого баримталж, мөнгө хэвлэж, тараасангүй. АНУ, Их Британи, Япон тэргүүт орон 2008 оны санхүүгийн

хямралын дараа мөнгөний уламжлалт бус бодлого баримталж, мөнгө хэвлэх нь ихэсжээ. Мөнгө хэвлэж, санхүүгийн хэрэгсэл буюу бонд, үнэт цаас худалдаж авах тренд одоо ч эрчээ алдаагүй байна. Хамгийн гол нь, Монголын Төв банк инфляцийг бууруулах зорилготойгоор мөнгө хэвлэсэн бол, Япон тэргүүт орон эдийн засгаа идэвхжүүлж, дефляциас гарахаар чармайж буйгаар ялгарч байгаа юм.

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн алдаа ба оноо

Замын-Үүд боомтын ачигчид жимс, жимсгэнийг хайр гамгүй шидэж, бяцалж, идэхийн аргагүй болгодог учраас бүтнээрээ ирсэн жимсний үнийг өсгөхөөс өөр арга байдаггүй гэж Хүнс импортлогчдын холбооны тэргүүн Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн анхны хэлэлцүүлэгт ярьж байв. Ердөө л ачигчийн буруугаас болж инфляци гаардаг гэхээр уншигч танд инээдтэй санагдаж мэдэх юм. Гэхдээ тухайн үеийн бодит байдлын дүр зураг энэ юм. Тиймээс ч хөтөлбөрийг хэрэгжүүлж, тээвэр ложистикийн асуудлыг шийдэх нь Төв банкны зорилт болж хувирсан байлаа. Ингээд мөнгө хэвлэн, тараах аянд Монголбанк нэгдэн оржээ.

Хүнс, барилга, тээвэр гэх мэт салбар бүрийн төлөөлөлтэй, Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн анхны хэлэлцүүлэгт оролцсон эрхмүүд их наядаар хэмжигдэх төгрөг хэвлэж, ам.долларын ханшийг чангатгах том хөтөлбөрийн шанг татаж буйгаа тухайн үед мэдээгүй гэдэгт итгэлтэй байна. Учир нь нийлүүлэлтийн гаралтай буюу тээврийн үнэ өндөр байдагтай холбоотойгоор

өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ огцом өсдөг гэсэн “онош”-ийг Төв банкны эдийн засагчид тавьсан нь бодит байдлын дүр зураг байсныг дээр дурдсан. Нэг л өглөө сэрэхэд гурилын үнэ 100, талхны үнэ 50 төгрөгөөр өсчихдөг байсны буруутныг бүгдээрээ нийлээд шатахуун руу чихдэг байсныг уншигч Та ч мартаагүй биз ээ.

Үүний зэрэгцээ Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг одоогийнхтой харьцуулахад тэнгэр, газар шиг ялгаатай байжээ. Бөмбөрцөг дэлхийд эдийн засгийн өсөлтөөрөө цойлж явсан Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүд урьд өмнө байгаагүй гайхамшигтай байсныг тоон дүнгүүд гэрчилдэг.

Статистик

2012 оны эцсийн байдлаар Монголбанкны гадаад валютын албан нөөц 4.1 тэрбум ам.долларт хүрч, рекорд тогтоов. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 68.4 хувиар өссөн дүн байдаг. Харьцуулахад, өнгөрсөн оны эцсийн байдлаар Монгол Улсын сан хөмрөг ширгэж, гадаад валютын албан нөөц 1.2 тэрбум ам.долларт хүрчээ.

2012 оны эцсийн байдлаар Монгол Улсад орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 4.4 тэрбум ам.долларт тэнцсэн нь өмнөх оны мөн үеэс 265 сая ам.доллараар буурсан дүн байв. Харьцуулахад өнгөрсөн оны эцсийн байдлаар 4.1 тэрбум ам.долларын алдагдалтай байгаа юм.

Энэ мэт эерэг үзүүлэлт, “эмнэлгийн оношийг” өмнөө барьсан Монголбанк инфляцитай дайн зарлаж, үнийг бат нот тогтворжуулах хөтөлбөрийг боловсруулжээ. Үр дүнд нь дэлхийн зах зээлд түүхий нефтийн үнэ шалдаа бууж байхад Монголын шатахуун түгээх станцууд АИ-92 маркийн бензинийг 1580 төгрөгөөр гурван жил дараалж борлуулсныг Та бид сайн мэднэ. Ердөө нэг жилийн дотор байрны үнэ 20.5 хувиар өссөн байдгийг Монголбанкнаас танилцуулдаг Орон сууцны үнийн индексээс хялбар харж болох юм. Энэ өсөлт 2014 оны эцсээс эхэлж тасралтгүй уруудсан байдаг. Хамгийн гол нь, Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн үр дүн анхны тооцоолоос халиад, барилгын салбарт гэхэд л хөөс үүсгэснийг Та харж байна.

Монголбанкнаас албан ёсны мэдээлэл хараахан өгөөгүй боловч УИХ-ын гишүүн Т.Аюурсайханаар


ахлуулсан ажлын хэсгийн шалгалтын дүнгээр Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд 4.8 их наяд төгрөг зах зээлд нийлүүлсэн гэх мэдээлэл бий. Өөрөөр хэлбэл, төдий хэмжээний төгрөг хэвлээд, мөнгөний нийлүүлэлтээ нэмэгдүүлсэн гэсэн үг. Үүний 3.7 их наяд төгрөгийг барилгын салбарт зарцуулжээ. Ингээд үнийг тогтвортой байлгахаар онилсон Монголбанкны бодлого бодит амьдралд хэрэгжихдээ буруу эргэлт хийснийг Та бид харж байна.

Мөнгө хэвлэх бодлого ба Япон, АНУ-аас авах сургамж

Үнэндээ мөнгө хэвлэж, эдийн засгаа эрчимжүүлэх бодлогыг “төрүүлсэн” улс бол дефляцид идэгдсэн Япон юм. Тэд анх 2001 онд мөнгө хэвлэх замаар дефляциас гарах оролдлого хийж эхэлжээ. Японы Төв банк шинэ мөнгө хэвлэх замаар үнэ хөөрөгдөхийг хичээдэг гэнэ. Ингэснээр зогсонги байдалд орсон эдийн засаг эргэлтэд ордог аж. Хамгийн гол нь, инфляцитай орны иргэд мөнгөө хадгалах сонирхолгүй болдог учраас бизнес эрхлэлт нэмэгдэж, эдийн засаг өсдөг аж. Харин дефляцитай үед иргэдийн хадгаламж өсөж, эдийн засаг зогсонги байдалд ордог аюултай юм байна. Тиймээс л Японы Төв банк дефляциас гарахын тулд мөнгө хэвлэх замаар эдийн засгаа эрчимжүүлдэг аж.

Гэхдээ мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар эдийн засгаа идэвхжүүлэх бүх оролдлого санасны зоргоор амжилттай болсон гэж хэлэхэд хэцүү. Тухайлбал, 2008 оны санхүүгийн хямралын дараа АНУ-ын Холбооны нөөцийн банкны тэргүүн асан Бен Бернанке “нисдэг тэрэг” хоч автлаа мөнгө хэвлэн, тараажээ. Түүнийг шинээр хэвлэсэн “ногооноо” тэнгэрээс цацдаг гэж шоглох нь ч бий. Өдгөө ч АНУ-ын мөнгө хэвлэж, санхүүгийн хэрэгсэл худалдаж авах бодлогоо бүрэн дүүрэн халаагүй. Хамгийн гол нь, мөнгөний уламжлалт бус энэ бодлогыг зогсооход үүсэх эрсдэл их гэдэгтэй эдийн засагчид санал нэгддэг аж.

Эцэст нь, Замын-Үүд боомтын ачигч жимснүүдийг хайр гамгүй шидэж, няцалдагас болж жимсний үнэ тэнгэрт хаддаг байсан Монголын инфляцийн бодит төрх өдгөө дефляцийн эрсдэлд орсон. Инфляцитай тэмцэхийн тулд мөнгө хэвлэж тараах уламжлалт бус арга сонгож байсан Монголбанк өдгөө уламжлалт арга барилаар ажиллана гэдгээ удаа дараа мэдэгдэж байна. Ер нь инфляцийг аргалах, арга чарга байна уу, та минь ээ.




Монгол Улсын Импортын бүтэц




2017 оны 07-р сар

Импорт 2017 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 27%-иар буюу 504 сая ам.доллараар өссөн. Импортын өсөлтийг ерөнхий ангилалаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 14%, нефтийн бүтээгдэхүүн 11%, хэрэглээний бүтээгдэхүүн 3%-иар тус тус өссөнөөр тайлбарлаж байна. Хэрэглээний бүтээгдэхүүний нийт импортод эзлэх жин өнгөрсөн оны мөн үеэс 5%-иар буурсан бол нефтийн бүтээгдэхүүний жин 5%-иар өсчээ.


Импортын зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүн (сая ам.доллар)



Томоохон импортлогч орнууд



Импорт, барааны бүлгээр (сая ам.доллар)





МОНГОЛБАНКНЫ УДИРДАХ АЖИЛТНЫ БҮСИЙН ЗӨВЛӨГӨӨНҮҮД АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ ДУУСЛАА

Монголбанкны Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн 5 шинэчлэлийн хүрээнд 2017 оныг “Орон нутаг дахь салбар, хэлтсийг бэхжүүлэх, боловсон хүчнийг чадваржуулах” жил болгон зарласантай холбогдуулан анх удаа Баруун, Зүүн, Хангайн, Говийн бүсийн Монголбанкны удирдах ажилтны зөвлөгөөнийг амжилттай зохион байгууллаа.

Зөвлөгөөний гол зорилго:

- Монголбанкны орон нутаг дахь салбар, хэлтсийн ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх;
- Төв болон орон нутгийн ажилтнуудын ажлын уялдааг дээшлүүлж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;
- Орон нутгийн иргэдэд эдийн засгийн нөхцөл байдал, төв банк ба мөнгөний бодлоготой холбоотой мэдээлэл хүргэх;
- Оюутан сурагчдад төв банкны үйл ажиллагаа, мөнгөний бодлогын талаар мэдлэг олгох;
- Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнууд, сэтгүүлч нарын ур чадварыг дээшлүүлэх, эдийн засгийн чиглэлээр мэргэшихэд хувь нэмэр оруулах.

Баруун бүсийн Монголбанкны удирдах ажилтны зөвлөгөөн 2017.07.20-ноос 25-ны өдрүүдэд Увс аймгийн төв Улаангомд зохион байгуулагдаж, Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баярсайханаар ахлуулсан ажлын хэсэг, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймаг дахь Монголбанкны салбарын захирал, ажилтнууд оролцсон.



Хангайн бүсийн Монголбанкны удирдах ажилтны зөвлөгөөн 2017.08.10-14 өдрүүдэд Өвөрхангай аймгийн төв Арвайхээр суманд зохион байгуулагдаж, Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэнгээр ахлуулсан ажлын хэсэг, Өвөрхангай, Орхон, Дархан-Уул, Баянхонгор, Хөвсгөл, Архангай аймаг дахь Монголбанкны хэлтэс, салбарын захирлууд, ажилтнууд оролцсон.



Зүүн бүсийн Монголбанкны удирдах ажилтны зөвлөгөөн Сүхбаатар аймгийн төв Баруун-Урт суманд 2017.09.06-наас 11-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх Д.Аюушаар ахлуулсан ажлын хэсэг, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймаг дахь Монголбанкны салбарын захирлууд, ажилтнууд оролцсон.



Говийн бүсийн Монголбанкны удирдах ажилтны зөвлөгөөн Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотод 2017.09.20-ноос 25-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэгээр ахлуулсан ажлын хэсэг, Өмнөговь, Дундговь, Дорноговь аймаг дахь Монголбанкны хэлтэс, салбарын захирлууд, ажилтнууд оролцсон.



Орон нутгийн Монголбанкны төлөөллүүд бүсийн зөвлөгөөнүүдийг амжилттай зохион байгууллаа гэж онцлоод, бүсийн зөвлөгөөнийг цаашдаа жил бүр зохион байгуулбал үр дүнтэй, туршлага солилцсон, орон нутгийнхан хоорондоо танилцсан сайн арга хэмжээ болно гэж дүгнэсэн юм.

МОНГОЛБАНКНЫ ДАЛБАА АЛТАЙ ТАВАН БОГД УУЛЫН ОРГИЛД МАНДАВ



Монголбанкны Дотоод аудитын газрын хянан шалгагч Пунцагдорж овогтой Батзул нь далайн түвшнээс дээш 4,051 метрийн өндөрт орших Алтай Таван Богд уулын "Малчин" оргилд 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдөр өглөөний 07:00 цагт авиралт хийж 11:00 цагт амжилттай гарч, Монголбанкны бэлгэдэл болсон цэнхэр далбааг мөнх хөх тэнгэртээ мандуулаад ирсэн байна.

Алтай Таван Богд уул нь Монгол Улсын хамгийн өндөр уул юм. Энэ ч утгаараа Монгол орны дээвэр хэмээгддэг билээ. Алтай Таван Богд уул нь Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Улаанхус сумдын заагт оршдог. Алтай Таван Богд уул нь таван үндсэн оргилтой ба Монголын хамгийн том гурван мөсөн гол болох Потанины мөсөн гол, Александрын мөсөн гол, Гранегийн мөсөн голууд оршдог. Эдгээрээс хамгийн том нь Потанины мөсөн гол бөгөөд 14 орчим км урттай. "Хүйтэн" оргил нь Алтай Таван Богд уулын ноён оргил юм. Найрамдал оргил нь Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хилийн зурвасын уулзвар, гурвалсан цэг юм.

Анхлан 1956 онд Монголын уулчид авирч байснаас хойш 700 гаруй уулчид авирсан ба өдгөө гадаад, дотоодын уулчдын авирах дуртай уул болоод байна.

1996 онд Алтай Таван Богд уул, Хотон, Хурган, Даян нуур, Ховд, Хар салаа, Цагаан салаа, Сонгинот, Ёлт зэрэг голуудын ай савуудыг хамруулан Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газар хэмээн улсын тусгай хамгаалалтад авсан байна. 2012 онд Алтай Таван Богд уулыг "Төрийн тахилгат уул" болгон 4 жилд нэг удаа тахиж байхаар болжээ.

Алтай Таван Богд уулын үндсэн таван оргил:

№	Нэр	Далайн төвшинөөс дээш өндөр(метр)
1.	Хүйтэн оргил	4,374
2.	Найрамдал оргил	4,192
3.	Бүргэд оргил	4,068
4.	Малчин оргил	4,051
5.	Өлгий оргил	4,050



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



САНГИЙН ЯАМ



БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО

“САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ” АЯН

2017.10.03 - 2017.12.31



@mongolbank_mn



@mongolbank.mn



mongolbank



www.mongolbank.mn

МОНГОЛБАНК “САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ” АЯН ЗАРЛАЖ БАЙНА

Үндэсний хэмжээнд хэрэгжиж буй “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанк “Санхүүгийн боловсрол” аяныг санаачлан 2017 оны 10 дугаар сарын 02-ноос 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл 3 сар хугацаатай хэрэгжүүлэхээр боллоо.

“Санхүүгийн боловсрол” аяны хүрээнд Монголбанк, БСШУСЯ, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон бусад хамтрагч байгууллагууд бүх нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэхэд хамтран оролцох бөгөөд санхүүгийн боловсролын үндсэн суурь ойлголтуудын талаар олон нийтэд хандсан сургалт, уулзалтуудыг хийх юм.

Тус аян нь санхүүгийн үйлчилгээтэй холбоотой мэдлэг, мэдээллээр хангах, аливаа санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, оновчтой шийдвэр гаргадаг байх, хувийн болон өрхийн санхүүгээ удирдах зөв дадал, хэвшилтэй болгосноор мөнгөө зөв удирддаг болох гэх мэтчилэн суурь ойлголтуудыг түгээн улс орны хөгжилд иргэн бүр өөрийн гэсэн хувь нэмрээ оруулах боломжийг нэмэгдүүлэхийн төлөө зорьж байна.